



## Шинжээчийн үнэлгээний тайлан

Байгууллагын нэр: **АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛЬ  
МОНГОЛ АНАГААХ УХААНЫ ОЛОН УЛСЫН ИХ СУРГУУЛЬ**

Хөтөлбөрийн нэр: **“ЗҮҮ ТӨӨНӨ ЗАСАЛ”**

Индекс: **D 091703**

Шинжээчийн баг:

Ахлагч: У.Мягмаржав

Гишүүд: С.Оюунцэцэг

Л.Анхцацрал

Л.Оюунцэцэг

**2023 ОН**

## **АГУУЛГА**

### **Товчилсон үгийн тайлбар**

**I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт**

**II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга**

**III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт**

Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

**IV. Уулзалтад оролцогчдын нэрс**

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс

IV. Төгсөгчдийн нэрс

**V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал**

**ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр**

**ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр**

## Товчилсон үгийн тайлбар

АНУ – Америкийн Нэгдсэн Улс  
АСБ – Анагаахын суурь боловсрол  
АУ – Анагаах ухаан  
АУС – Анагаах Ухааны Сургууль  
АУТНС – Анагаах Ухааны Төв Номын Сан  
АШУУИС – Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль  
БМИҮЗ – Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөл  
БНХАУ – Бүгд Найрамдах Хятад Ард Улс  
БОЭТ – Бүсийн оношилгоо эмчилгээний төв  
БСШУС – Боловсрол соёл, шинжлэх ухааны сайд  
БСШУЯ – Боловсрол соёл, шинжлэх ухааны яам  
БХЦСГ – Багшийн хөгжил, цахим сургалтын газар  
ДАУБХ – Дэлхийн Анагаах Ухааны Боловсролын холбоо  
ДЭМБ – Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага  
ЕБС – Ерөнхий боловсролын сургууль  
ЗТЗ – Зүү төөнө засал  
ЗХНГ – Захиргаа, хүний нөөцийн газар  
ИСНЭ – Их Сургуулийн Нэгдсэн Эмнэлэг  
МАУ – Монгол Анагаах Ухаан  
МАУОУС – Монгол Анагаах Ухаан Олон Улсын Сургууль  
МАУОУСОЗ – Монгол Анагаах Ухааны Олон Улсын Сургуулийн Оюутны Зөвлөл  
МАУОУСОН – Монгол Анагаах Ухааны Олон Улсын Сургуулийн Оюутны Нийгэмлэг  
МАУСТ – Монгол Анагаах Ухаан Судлалын Тэнхим  
МАУТЭ – Монгол Анагаах Ухааны Төв Эмнэлэг  
МТА – Мэдээлэл технологийн алба  
МҮА – Мэргэжлийн Үйл Ажиллагаа  
НЭМС – Нийгмийн Эрүүл Мэндийн Сургууль  
ОХУ – Оросын Холбооны Улс  
ОХУГ – Оюутны хөгжил удирдлагын газар  
ӨҮТ – Өөрийн үнэлгээний тайлан  
СБЗГ – Сургалтын бодлого зохицуулалтын газар  
ТББ – Төрийн бус байгууллага  
ТӨСА – Төгсөлтийн өмнөх сургалтын алба  
ТӨСБЗГ – Төгсөлтийн өмнөх сургалтын бодлого зохицуулалтын газар  
ТҮЦМ – Түргэн үйлчилгээний цахим машин  
УАУ – Уламжлалт Анагаах Ухаан  
УАУИС – Уламжлалт Анагаах Ухааны Их Сургууль  
УАУТХЭ – Уламжлалт Анагаах Ухаан Технологийн Хүрээлэнгийн Эмнэлэг  
ХАУ – Хятад анагаах ухаан  
ЭМХТ – Эрүүл мэндийн хөгжлийн төв  
ЭМШУИС – Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль  
ЭМШУТНС – Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Төв Номын Сан  
ЭМЯ – Эрүүл Мэндийн Яам  
ЭШ – Эрдэм шинжилгэ

## I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

<b>Сургуулийн нэр</b> /Монгол, Англи/	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль монгол анагаах ухааны олон улсын их сургууль	
<b>Сургалтын хөтөлбөрийн нэр</b> /Монгол, Англи/	Зүү төөнө засал	
<b>Индекс</b>	091703 бакалавр	
<b>Шинжээчид</b>	1.У. Мягмаржав -Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн Дээд боловсролын хөтөлбөр, үнэлгээ хариуцсан ЭШ-ний ажилтан 2. С.Оюунцэцэг- Шинэ анагаах ухааны Их сургуулийн НСМ-Эрдмийн сургуулийн захирал, доктор 3. Л.Анхцацрал -Ач анагаах ухааны Их сургуулийн Уламжлалт анагаахын сургуулийн Эмнэл зүйн тэнхмийн эрхлэгч, доктор 4. Л.Оюунцэцэг- МУИС-ийн Бизнесийн сургуулийн НББ-ийн тэнхмийн эрхлэгч, доктор, дэд профессор	
<b>БМИҮЗ-ийн ажлын албаны мэргэжилтэн</b>	Магадлан итгэмжлэл хариуцсан шинжээч Б.Оюунцэцэг	
<b>Төлөвлөгөө</b>	2023.01.06	Мэргэжилтэн шинжээчдэд ӨҮТ-г хүлээлгэн өгөх
	2023.01. 11	Шинжээчийн урьдчилсан үнэлгээний тайланг мэргэжилтэнд өгөх
	2023.01.16	Сургуулийн бэлэн байдлыг нягтлах
	2023.01.17-18	Шинжээчид сургууль дээр ажиллах
	2023.01.27	Шинжээчийн баг зохицуулагчид шинжээчийн тайланг илгээх
	2023.01.30	Магадлан итгэмжлэлд орж буй сургуульд шинжээчийн тайланг илгээх
	2023.02.01	Сургууль шинжээчийн тайлантай танилцаж хариу өгч, шинжээчийн тайлан эцсийн байдлаар бэлэн болох
		Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр гарах
<b>Шалгуур шаардлага</b> /журам/	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2016 оны 03 дугаар сарын 15-ний өдрийн 001 дугаар тогтоолоор батлагдсан “Шалгуур, шаардлага шинэчлэн батлах тухай” тогтоолын Хоёрдугаар хавсралтаар батлагдсан шалгуур шаардлагын дагуу ажиллав.	

Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайланг шинжээчийн баг сургуульд ажиллахаас хоёр долоо хоногийн өмнө хүлээн авч, уншиж танилцсан. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний

тайлан нь өмнөх үг, үндсэн 7 шалгуур, шаардлага гэсэн бүтэцтэй бичигдсэн байна, шалгуур бүрд чанарын менежментийн PDCA циклийн дагуу дүгнэлт, SWOT шинжилгээ хийгдсэн. Шинжээчийн баг тайлангийн бүтэц, бичилтийн агуулга нь магадлан итгэмжлэлийн хөтөлбөрийн шаардлага, үзүүлэлтэд нийцэж байгаа эсэх, статистик судалгааны дүгнэлт, өгөгдлийн нотлох баримтууд зэргийг нягтлан үзэж, урьдчилсан байдлаар тайланд тодорхойгүй байгаа хэсгүүдийг тодорхойлж, тодруулах асуултуудыг гаргаж, сургуульд ажиллах явцдаа нотлох баримтуудтай танилцсан.

## **II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга**

АШУҮИС-ийн МАҮОУС нь 30 жилийн түүхтэй Уламжлалт анагаах ухааны боловсрол олгодог ууган, төрийн өмчит сургууль бөгөөд өнгөрсөн жилүүдэд Монгол улсын эрүүл мэндийн салбарт мэргэжсэн боловсон хүчнийг бэлтгэж, үйл ажиллагааны цар хүрээг тэлэн шинэ мэргэжил, ангиудыг нээж сургалт зохион байгуулж байна.

БСШУЯ-ны Сайдын 2007 оны 3 сарын 27-ны өдрийн 88 тоот тушаал, Боловсролын хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу олон улсад болон дотооддоо магадлан итгэмжлэгдсэн гадаадын их дээд сургуулийн сургалтын хөтөлбөрийг Монгол улсад нэвтрүүлэх зорилгоор БНХАУ-ын Тяньжины УАУИСтэй хамтран Уламжлалт Анагаахын Сургуульд зүү төөнө заслын чиглэлээр бакалаврын боловсрол олгох сургалт явуулах гэрээ хийгдсэний дагуу шинэ анги нээх боломжтой гэж үзсэн Эрүүл мэндийн Шинжлэх Ухааны Их Сургуулийн захирлын 2011 оны 09 сарын 27-ны өдрийн А/28 тоот албан бичгээр БСШУЯ Мэргэжлийн боловсролын газарт илгээжээ.

1. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2012 оны 10 сарын 10-ны өдрийн №960003 тусгай зөвшөөрөлд Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь зүйл, Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2, 28.1.3 дахь заалт, Дээд боловсролын тухай хуулийн 8.10 дахь хэсгийг үндэслэн ШУС-ын 1996 оны 03 сарын 09-ний өдрийн А/84 тоот тушаалын дагуу "Уламжлалт Анагаах Ухаан /Зүү засал/" D722002 индекс бүхий өдрийн хөтөлбөрийг баталсан.
2. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2018 оны 10 сарын 10-ны өдрийн №960003 тусгай зөвшөөрөлд БШУСЯ-ны сайдын 2014 оны 03 сарын 13 ний А/78 тушаалаар батлагдсан Зүү төөнө засал D 091703 индекс бүхий хөтөлбөрийг баталсан.
3. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2021 оны 05 сарын 19-ны өдрийн №960003 тусгай зөвшөөрөлд БШУСЯ-ны сайдын 2014 оны 03 сарын 13 ний А/78 тушаалаар батлагдсан Зүү төөнө засал D 091703 индекс бүхий хөтөлбөрийг баталсан.
4. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2021 оны 05 сарын 19-ны өдрийн №960003 тусгай зөвшөөрөлд БШУСЯ-ны сайдын 2014 оны 03 сарын 13 ний А/78 тушаалаар батлагдсан Зүү төөнө засал хөтөлбөрийг D 091703 индекс нь БШУСЯ-ны сайдын 2022 оны 05 сарын 09 ний А/160 тушаалаар Зүү төөнө засал D 091703 болж өөрчлөгдсөн

**Хөтөлбөрийн тодорхойлолт:** Зүү төөнө заслын сургалтын хөтөлбөр нь сум өрхийн, аймаг дүүргийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо, тусгай мэргэжлийн төвүүд, төв эмнэлгийн эмчилгээний түвшинд зүү төөнө заслын мэргэжлээр ажиллах орчин үеийн мэдлэгтэй, оношлох эмчлэх чадвар эзэмшсэн, зүү хатгах аргад дадлагажсан, мэргэжлийн эмч нарт зөвлөгөө өгөх чадвартай, зүү төөнө заслын төрөлжсөн нарийн

мэргэжлээр цаашид мэргэших боломжтой зүү төөнө заслын эмч мэргэжилтэн бэлдэхэд чиглэнэ.

**Хөтөлбөрийн зорилго:** Зүү төөнө заслын онол болон орчин үеийн анагаах ухааны нэгдмэл сургалтын хөтөлбөрөөр чадамжид суурилсан бакалаврын боловсрол эзэмших.

**Хөтөлбөрийн зорилт:**

1. Зүү төөнө заслын сөрөг нөлөө багатай, үр дүнтэй, эмийн бус эмчилгээний аргыг Монгол улсад хөгжүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг шатлал бүрт ЗТЗ-аар эмчлэх ур чадвартай мэргэжилтэн бэлтгэх
2. Сургалтын чанарыг тасралтгүй сайжруулж, төгсөгчдийн ур чадварыг нэмэгдүүлэн, зах зээлийн эрэлт хэрэгцээг хангах
3. Төгсөлтийн дараах сургалтанд суралцах боломжийг бий болгон, төгсөгчдийн тасралтгүй суралцах эрхийг хангах
4. Төгсөгчдийг өөрийн орны болон гадаад улсад зүү төөнө заслын их эмчээр ажиллах эмчлэх эрхийн лицензийн шалгалтын агуулгыг сургалтын хөтөлбөрт тусгах

**Төгсөгчийн тодорхойлолт:** Зүү төөнө заслын их эмч нь ХАУ-ны болон орчин үеийн анагаах ухааны тодорхой түвшний мэдлэг, эмнэл зүйн болон оношилгоо, гардан үйлдлийн ур чадвартай, мэргэжлийн эерэг хандлага эзэмшсэн, мэдлэг ур чадвар дээр суурилан мэдээллийг цуглуулж тайлбарлах, эмнэл зүйн шийдвэр гаргахад санал өгөх, багаар хамтран ажиллах чадвартай байна.

**Бакалаврын сургалт дүүргэсэн зүү төөнө заслын их эмч нь:**

- Тохиолдож буй эмнэл зүйн асуудлыг шийдвэрлэх
- Төгсөлтийн сургалтад хамрагдаж мэдлэг мэргэжлээ тасралтгүй дээшлүүлэх
- Нотолгоонд суурилсан анагаах ухааныг эмнэл зүйд хэрэглэх
- Зөв харилцаа, хандлагатай
- Хөгжил дэвшилд эергээр хандах чадвартай байна.

**Үнэт зүйлс:**

- Ёс зүйтэй, харилцааны соёл
- Сургалтын 30-аад жилийн туршлага
- Нэгдмэл сургалтын хөтөлбөр
- Өндөр чадавхтай боловсон хүчин
- Эрдэм судлалын эрх чөлөө
- Академик байгууллагын бие даасан байдал
- Эрүүл мэндийн салбарын эрэлт хэрэгцээнд нийцсэн төгсөгчид

Зүү төөнө заслын эмчийн гурван удаагийн төгсөлтөөр нийт 45 оюутан төгссөн, жил бүр 45 оюутан элсүүлдэг нийт суралцагчийн тоо 163 байна.

**Сургалтын төлөвлөгөөний бүтэц**

АШУҮИС-ын захирлын 2016 оны 09 сарын06-ны өдрийн сургалтын төлөвлөгөө, багшийн орон тоо, албан тушаалын зэрэглэлийг батлах тухай А/87 тоот тушаалаар эрүүл мэндийн чиглэлийн хөтөлбөрийн суурь сургалтыг 2 жилийн хугацаатай нийт 68 багц цаг судлахаар төлөвлөсөн байна. 2013 онд төлөвлөсөн 75 баг цагийг 68 болгон өөрчилсөн байна. Харин мэргэжлийн хичээлийн баг цагийн хэмжээ 148 баг цаг хэвээр хадгалагдаж байна. Одоогийн хэрэгжүүлж буй АШУҮИС-ийн захирлын 2016-11-07-ны А/142 тоот тушаалаар баталсан Монгол Анагаах ухааны Сургуулийн Зүү төөнө заслын сургалтын төлөвлөгөөний дагуу нийт 216 кр цаг судлахаар тусгасан байна.

- Ерөнхий суурь хичээл: 53+2 (сонгон) багц цагийн хичээлүүд- 25.5%

- Мэргэжлийн суурь хичээл: 58+2 (сонгон) багц цаг-27:8%
- Мэргэшүүлэх хичээл: 103 багц цаг (2 кр сонгон хичээл, Дадлагажигч эмчийн сургалт 26 кр, эмнэлзүйн дадлага 8 кр) -46.7% байна.

### **III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт**

#### **Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт**

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

#### **1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага**

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

#### **Илрэл нотолгоо:**

- ДЭМБ-ын стратеги болон АНУ-ын National Health Interview Survey 2007 судалгааны мэдээлэл, зарим эрдэмтдийн судалгааны өгүүлэлд үндэслэн эрэлт хэрэгцээтэй гэж үзсэн
- Монгол улс уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх стратеги бодлогын хүрээнд БНХАУ-ын засгийн газрын тэтгэлгээр 1989 – 1995 онд жилд 25 оюутан, 1996-2011 онд жилд 50 оюутан суралцагчдад бүрэн тэтгэлэгтэй суралцсанаас 20% нь буюу 200 гаруй оюутан анагаах ухаан, Хятад анагаах ухаан, зүү төөнө заслын чиглэлээр мэргэжил эзэмшин төгссөн байна.
- АШУҮИС өөрийн хөгжлийн стратегийг боловсруулсны үндсэн дээр МАУОУС өөрийн хөгжлийн стратеги үзэл баримтлалаа боловсруулан түүнийг хэрэгжүүлэх, дунд хугацааны төлөвлөгөө гарган хэрэгжүүлжээ.
- ЭМШУИС-ийн УАС-ийн Зүү төөнө засал сургалтын хөтөлбөр нь ДЭМБ-ийн зүү төөнө заслын сургалтын бенчмарк болон Дэлхийн зүү төөнө заслын нийгэмлэгийн хятад анагаах ухааны үндсэн сургалтын хөтөлбөрийн стандартыг эх болгон, БНХАУ-ын Тяньжинийн их сургуулийн хөтөлбөртэй уялдуулан боловсруулсан. АШУҮИС, МАУОУС, АНУ, БНХАУ-ын Тяньжины Хятад Анагаах Ухааны Их Сургууль, Гуанжоу хотын Хятад Анагаах Ухааны Их Сургууль, Шанхай хотын Уламжлалт Анагаах Ухааны Их Сургуулийн бакалаврын хөтөлбөрийн харьцуулалтыг хийлээ. АШУҮИС-ийн зүү төөнө заслын хөтөлбөрт Тяньжины ХАУИС-ийн зүү төөнө заслын ангид ордог хичээлүүдийн 85% тусгагдсан байна. Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээлийн агуулга, хичээлийн тоо, нийт кредит, суралцах хугацаа, мэргэжлийн нэр зэрэг үзүүлэлтийг шалгуур болгон авсан байна.
- Гадны их сургуулиудын Зүү төөнө заслын их эмчийн хөтөлбөрүүдтэй харьцуулахад АШУҮИС-ийн МАУОУС-д 6 жил суралцахдаа хамгийн өндөр кредит судалдаг ба нэг хичээлийн жилийн ноогдолоор дундаж буюу 36 кр, харин АНУ-ын Дорнын АУ-ны Орегон коллеж, Солонгосын Кюнхэ их сургууль, Шанхай УАУ-н их сургууль нийт 280 кр нэг жилд 50-60 кр хичээлийг үзэж судалдаг байна.
- АШУҮИС-ийн МАУОУС нь анагаахын суурь боловсролын стандарт хэрэгжсэнтэй холбогдуулан сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, салбарын болон ирээдүйн мэргэжилтнүүдийн хэрэгцээнд нийцүүлэх зорилгоор Зүү төөнө заслын эмчийн сургалтын хөтөлбөрийн агуулгыг сайжруулсаар ирсэн байна..

**Онцлог зүйл:**

АШУУИС-ийн МАУОУС нь 30 жилийн түүхтэй Уламжлалт анагаах ухааны боловсрол олгодог ууган, төрийн өмчит сургууль бөгөөд 1989 оноос эхлэн уламжлалт анагаах ухааны хөтөлбөрийг хэрэгжүүлжээ.

1. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2012 оны 10 сарын 10-ны өдрийн №960003 тусгай зөвшөөрөлд Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь зүйл, Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2, 28.1.3 дахь заалт, Дээд боловсролын тухай хуулийн 8.10 дахь хэсгийг үндэслэн ШУС-ын 1996 оны 03 сарын 09-ний өдрийн А/84 тоот тушаалын дагуу "Уламжлалт Анагаах Ухаан /Зүү засал/" D722002 индекс бүхий өдрийн хөтөлбөрийг баталсан.
2. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2018 оны 10 сарын 10-ны өдрийн №960003 тусгай зөвшөөрөлд БШУСЯ-ны сайдын 2014 оны 03 сарын 13 ний А/78 тушаалаар батлагдсан Зүү төөнө засал D 091703 индекс бүхий хөтөлбөрийг баталсан.
3. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2021 оны 05 сарын 19-ны өдрийн №960003 тусгай зөвшөөрөлд БШУСЯ-ны сайдын 2014 оны 03 сарын 13 ний А/78 тушаалаар батлагдсан Зүү төөнө засал D 091703 индекс бүхий хөтөлбөрийг баталсан.
4. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2021 оны 05 сарын 19-ны өдрийн №960003 тусгай зөвшөөрөлд БШУСЯ-ны сайдын 2014 оны 03 сарын 13 ний А/78 тушаалаар батлагдсан Зүү төөнө засал хөтөлбөрийг D 091703
5. индекс нь БШУСЯ-ны сайдын 2022 оны 05 сарын 09 ний А/160 тушаалаар Зүү төөнө засал D 091703 болж өөрчлөгдсөн
6. Хятад хэлний HSK4 төвшний шалгалтыг амжилттай өгч шаардлага хангасан суралцагчид хамтран ажиллах гэрээний хүрээнд БНХАУ-ын Тяньжин хотын УАУИС-д 2 жилийн хугацаатай шилжин суралцаж "Зүү төөнө засал" 4+2 хос диплом эзэмших бүрэн боломжтой.
7. Хөтөлбөрийн 82 хичээлийг БСШУ-ны Сайдын 2014 оны 4-р сарын 28-ны өдрийн А/174 тушаалын дагуу боловсруулсан.

**Анхаарах асуудал:**

-Хөтөлбөрийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлоход тусгасан мэдээллийн эх сурвалжыг тодорхой болгох

-Хөтөлбөрийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлохдоо хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээний судалгаа авах, хөтөлбөрт оролцогч талуудын хэрэгцээг судалж дүн шинжилгээ хийх

**Зөвлөмж:**

- Хөдөлмөрийн зах зээлийн судалгааг хийж хөтөлбөрийн сайжруулалтанд оролцогч талуудын саналыг тусгадаг байх

**Дүгнэлт:**

Тус хөтөлбөр нь олон жилийн түүхтэй тасралтгүй хэрэгжсээр ирсэн хөтөлбөр бөгөөд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээний судалгаа, хөтөлбөрийн оролцогч талуудын саналд дүн шинжилгээ хийж сайжруулах боломжтой гэж үзсэн тул тус дэд шалгуурыг бүрэн хангасан үнэлгээг өгч байна.

**Үнэлгээ: Бүрэн хангасан**



## **1.2 Хөтөлбөрийн зорилго**

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

### **Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлохдоо Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хуулийн холбогдох заалтуудад үндэслэн боловсруулсан байна.
- Хөтөлбөрийн боловсролын зорилго, зорилтууд (PEOs) болон дотоод, гадаадын магадлан итгэмжлэлийн байгууллага эсвэл боловсролын стандарт, шаардлагаар тодорхойлогдсон төгсөгчдийн онцлог шинжүүдийг харгалзан Зүү төөнө заслын хөтөлбөрийн зорилгыг боловсруулан хэрэгжүүлж байна.
- Тухайлбал, Хөтөлбөрийн зорилгыг АШУҮИС-ийн Шинжлэх ухаан боловсрол, эрүүл мэндийн салбарт манлайлагч их сургууль байх эрхэм зорилготой Уламжлалт анагаах ухааны сургалтыг шинэ түвшинд гарган хүний нөөцийг чадавхжуулан эмнэл зүйн удирдамж, технологийн шинэчлэл бүхий уламжлалт эм бэлдмэлийг гарааны компани байгуулан үйлдвэрлэх замаар эмнэлэг үйлчилгээний ашиг орлогыг нэмэгдүүлэн судалгааны их сургуулийн QS шалгуурт тэнцэх зэрэг зорилгуудтай уялдуулж Зүү төөнө заслын хөтөлбөрийн зорилгыг “Зүү төөнө заслыг нотолгоонд суурилсан, аюулгүй, хоргүй, үр дүнтэй, эмийн бус эмчилгээний аргыг хөгжүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг шатлал бүрт ЗТЗ-аар эмчлэх ур чадвартай мэргэжилтэн бэлтгэх” хэмээн тодорхойлжээ.

### **Онцлог зүйл:**

- Зүү төөнө заслын сургалтын хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн цагаас эхлэн суралцагч оюутан, багш, төгсөгчдөөс болон ажил олгогчоос авах жишиг асуумжийг боловсруулан, шат дараатайгаар судалгаа аван, хөтөлбөрийн зорилго, төгсөгчдийн эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагыг үнэлэн хэлэлцэж, шаардлагатай саналыг тусган хэрэгжүүлж ирсэн.
- Хөтөлбөрөөр төгсөгчийн мэргэжлийн үйл ажиллагаа, эмнэлгийн удирдлагын менежмент, хятад анагаах ухааны суурь мэдлэг, оношилгоо эмчилгээний ур чадвар, аюулгүй ажиллагааны ур чадвар, харилцааны ур чадвар гэсэн 6 үндсэн мэдлэг ур чадварыг тодорхойлсон.
- Оюутны эзэмших мэдлэг ур чадварыг тохиолдож буй эмнэл зүйг асуудлыг шийдвэрлэх, төгсөлтийн сургалтад хамрагдаж мэдлэг мэргэжлээ тасралтгүй дээшлүүлэх, нотолгоонд суурилсан анагаах ухааныг эмнэл зүйд хэрэглэх, хөгжил дэвшилд эерэгээр хандах чадвартай, эмнэл зүйн багш, эмчийн хяналтад өвчтөнд сурилсан эмнэл зүйн дадлага, туршлагыг хангалттай түвшинд олж авах зөв харилцаа хандлагатай байх зэрэг 6 чиглэлийн мэдлэг чадвар, хандлага эзэмшинэ гэж тусгажээ.

### **Анхаарах асуудал:**

Төгсөгчийн ур чадварыг тодорхойлох судалгааны үр дүнд шинжилгээ хийх

### **Зөвлөмж:**

Хөдөлмөрийн зах зээл дэхь ажил олгогчоос төгсөгчийн ур чадварыг тодорхойлох судалгааг жил бүр авч хөтөлбөрийн хэрэгжилтэд ашиглах.

### **Дүгнэлт:**

Тус дэд шалгуурын хувьд анхаарах асуудлыг зөвлөмжийн дагуу сайжруулах боломжтой

### **Үнэлгээ: Бүрэн хангасан**

#### **1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд**

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага (A/174)-д нийцүүлж, сургалтын төлөвлөгөөг шинэчлэн боловсруулсан.
- Бакалаврын сургалтын хөтөлбөр боть I, II, III,
- Хөтөлбөрийн ерөнхий хорооны 2022 оны 06 сарын 17 өдрийн 03/22 хурлын тэмдэглэл
- Хичээлийн хөтөлбөрийн үлгэрчилсэн загвар
- АШУҮИС-ийн Анагаах Ухааны Сургуулийн захирлын 2014 оны 10 сарын 08-ны өдрийн А/27 тоот тушаалаар Монгол улсад “Мэргэжилтний цогц чадамж” анхдугаар хэвлэл боловсруулагдсан.
- Зүү эмчилгээний их эмчийн албан тушаалын тодорхойлолтын үлгэрчилсэн загвар Эрүүл мэндийн Сайдын 2021 06 сарын 23-ны А/405 тоот тушаал гарсан.

#### **Онцлог зүйл:**

- Хөтөлбөрийн чанарыг сайжруулах зорилгоор хөтөлбөрийн ерөнхий хороо, салбар хороодууд тодорхой төлөвлөгөөтэй ажлууд зохион байгуулж, тайлагнадаг.
- Төгсөгчийн хүрэх үр дүнг (PLOs) үйлээр илэрхийлэн тодорхойлсон
- Сургалтын төлөвлөгөөний хичээлүүд ба хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадварын жагсаалт хоорондын хамаарлыг харуулсан сургалтын төлөвлөгөөний матриц хийгдсэн
- АШУҮИС-ийн Захирлын 2016 оны 11 сарын 07-ны өдрийн хурлын шийдвэрээр батлагдсан D091703-“Зүү төөнө засал” индекс бүхий сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа бөгөөд 216 багц цагийн хичээлийг судалдаг.
- Зүү төөнө заслын сургалтын хөтөлбөрийн агуулгад жил тутам дүн шинжилгээ хийдэг бөгөөд 2017 онд сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан нийт 82 хичээлийн хөтөлбөрийг БШУ сайдын 2014 оны 04 сарын 28-ны А/174 тоот тушаалд дурдагдсан "Бакалаврын мэргэжлийн чиглэлд тавигдах нийтлэг шаардлага"-ын дагуу боловсруулж батлуулсан.
- 2021 онд мэргэжлийн суурь-13, мэргэшүүлэх-11, дадлагажих эмнэлзүйн сургалт-2 (6), нийт 30 хичээлийн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, сургалтанд хэрэгжүүлж байгаа болно.

#### **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрийг сайжруулахтай холбоотой төлөвлөлт, түүний хэрэгжилт биелэлтэд хийсэн дүн шинжилгээ дутмаг
- Сургалтын төлөвлөгөөний хичээл хоорондын залгамж холбоог харуулах

#### **Зөвлөмж:**

- Хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилтийн биелэлтэд дүн шинжилгээ хийж хөтөлбөрийн сайжруулалтад ашиглах
- Хичээл хоорондын залгамж холбоог харуулсан схем хийх

### **Дүгнэлт:**

Тус дэд шалгуурын хувьд анхаарах асуудлыг зөвлөмжийн дагуу сайжруулах боломжтой

**Үнэлгээ: Бүрэн хангасан**

## **ШАЛГУУР 1. ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ, ҮНЭЛГЭЭ:**

**ДҮГНЭЛТ:** Тус шалгуур нь нийт 3 дэд шалгууртай бөгөөд эдгээр шалгуурын хүрээнд анхаарах асуудлыг зөвлөмжийн хүрээнд сайжруулах бүрэн боломжтой гэж үзээд бүрэн хангасан гэж дүгнэлээ.

**ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ: БҮРЭН ХАНГАСАН**

## **Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа**

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

### **2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл**

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

### **Илрэл нотолгоо:**

Сургалтын үйл ажиллагааг шинэчлэн сайжруулсан төлөвлөлт, үр дүн (PDCA)

- Хөтөлбөрийн агуулгад дүн шинжилгээ хийж, хичээл хоорондын хамаарлуудыг харгалзан үзэж ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэжлийн чиглэлд ангилан нийт 216 кредит судлахаар төлөвлөсөн.
- Хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадварын жагсаалтыг гаргаж хичээлийн хөтөлбөртэй уялдуулж матриц хийсэн.
- Онол, дадлагын харьцааг тооцсон.
- АШУҮИС-ийн удирдлага мэдээллийн UNIMIS удирдлага мэдээллийн системийг ашиглаж байна. Оюутан хичээлээ өөрөө сонгох, багшаа сонгох боломжоор хангагдсан.
- Багшийн вэб-ээр дамжуулан дүнгийн дэлгэрэнгүй судалгаа гарах боломжтой.

### **Онцлог зүйл:**

- Хөтөлбөрийн агуулгыг өөрчлөх боломжтой уян хатан сургалтын хөтөлбөр төлөвлөгөөг хэрэгжүүлж ирсэн. Дээд боловсролын тухай хууль, БСШУ-ны Сайдын тушаал, шийдвэртэй холбогдон гарч буй дүрэм журам, ЭМЯ-ны стратеги бодлогод гарч буй өөрчлөлт зэрэг дотоод хүчин зүйлс, БНХАУ-ын Хятад Анагаах Ухааны боловсролын стандарт, WFAS олон улсын нийгэмлэгийн хууль журам, зөвлөмж

удирдамжуудыг үндэслэл болгон сургалтын хөтөлбөрт холбогдох өөрчлөлтүүдийг 2017, 2021 онуудад хийж сайжруулан баталгаажуулсан. Үүнд:

- Зүү төөнө заслын бакалаврын хөтөлбөрийн ерөнхий суурь хичээлийн багц цаг 2013 оны хөтөлбөрт 56 багц цаг байсныг 2014 онд 28 болгож бууруулсан. Үүнийг 2016 оны хөтөлбөрт 49 багц цаг болгон эргэж нэмэгдүүлсэн.
  - Мэргэжлийн суурь хичээл 2013 оны хөтөлбөрт 85 багц цаг, 2014 онд 90 байсныг 2016 оны хөтөлбөрт 58 багц цаг болгож багасгасан.
  - Харин мэргэшүүлэх хичээлийн хувьд 2013 оны хөтөлбөрт 55 багц цаг байсныг 2014 онд 85 болгож нэмэгдүүлсэн. Үүнийг 2016 оны хөтөлбөрт 65 багц цаг болгон эргэж бууруулсан. Дадлагажих эмнэлзүйн сургалт 2013 оны хөтөлбөрт 15 багц цаг байсныг 2014 оны хөтөлбөрт хасаж, 2016 оны хөтөлбөрт 26 багц цаг болгон нэмэгдүүлж оруулж ирсэн байна.
  - Ерөнхий суурь хөтөлбөрийн хүрээнд гадаад хэлний хувьд англи хэлний хичээлийг 8 багц цаг, сонгоноор хятад хэл 3 багц цагийг судалдаг байсан бол 2014 оны хөтөлбөрт англи хэл 3 багц цаг, сонгоноор 2 багц цаг, мэргэжлийн суурь хичээл дээр хятад хэлийг 10 багц цаг судалдаг болсон. 2016 оны хөтөлбөрт англи хэл 5 багц цаг, сонгоноор 2 багц цаг, хятад хэлийг 8 багц цаг судалдаг болсон байна.
  - 2013, 2014 оны хөтөлбөрт анатоми, гистологи, физиологи, бичил амь судлал, удам зүй, молекул биологи зэрэг хичээлүүдийг мэргэжлийн суурь хичээлээр судалдаг байсан бол 2016 оны хөтөлбөрт ерөнхий суурь хичээлийн хүрээнд судалдаг болсон.
  - Ерөнхий суурь хичээлийн сонгон хичээлүүд 2013 онд 8, 2014 онд 6 хичээл байсан бол 2016 онд 9 хичээлээс сонгон суралцах боломжтой болсон.
  - Хятад анагаах ухааны дотор өвчин судлал, ХАУ-ны онош зүй, ХАУ-ны хүүхдийн өвчин зэрэг мэргэшүүлэх хичээлийн багц цаг 2013 оны хөтөлбөрт 24 багц цаг байсан бол, 2014 оны хөтөлбөрт 54 багц цаг, 2016 оны хөтөлбөрт 49 багц цаг болж нэмэгдсэнээс гадна судлах хичээлийн тоо бас нэмэгдсэн.
  - Эмнэлзүйн дадлагын хувьд 2013 оны хөтөлбөрөөр сувилахуй болон эмийн ургамлын дадлагыг 4 багц цаг хийдэг байсан бол 2014 оны хөтөлбөрт Хятад, өрнийн АУ-ны эмнэлзүйн дадлага, ХАУ-ны эмнэлзүйн дадлагыг 8 багц цаг хийдэг байсан. Харин 2016 оны хөтөлбөрөөр танилцах дадлага, орчин үеийн анагаах ухааны эмнэлзүйн дадлага, ХУАУ-ны эмнэлзүйн дадлагыг 8 багц цаг хийдэг болж эмнэлзүйн дадлагыг түлхүү хийдэг болсон.
- 2016 онд Бакалаврын хөтөлбөрт тавих шаардлагын дагуу нийт багц цагийн 30% ерөнхий суурь, 25% мэргэжлийн суурь, 45% мэргэжлийн хичээл байхаар бүрдүүлж, тухайн хичээл тус бүрийн 20% бататгах цаг болох дадлагажих цагийг багтаасан
- 2013 оны сургалтын төлөвлөгөөнд нийт 8664 цагийн хичээл төлөвлөсний 60% (5304) нь танхимийн цаг, 40% (3440) нь танхимын бус цаг байсан бол 2016 оны төлөвлөгөөгөөр нийт 10369 цагийн хичээл төлөвлөсний 55.5% (5769) нь танхимийн цаг, 44.5% (4600) нь танхимын бус цаг байхаар тусгагдсанаар суралцагчийн бие даалтын цаг 4.5% (1160)-иар нэмэгдсэн. Энэ нь суралцагсдын мэргэжлийн ур чадвар болон хувь хүний ур чадваруудыг хөгжүүлэхэд чиглэгдсэн болно.
- Сонгон суралцах 20 нэр төрлийн хичээл бүхий 10 багц цагийн хичээл судлах боломжтой.

- АШУҮИС-ийн АУС-ийн захирлын 2015-09- 30 ны 107 тоот тушаалаар 20% бататгах цаг дадлагажих цагийг хийж гүйцэтгэх эмнэлзүй ур чадварын төвийг байгуулсан.
- Анагаахын суурь сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд АШУҮИС-ийн Сургалтын бодлого зохицуулалтын газрын захирлын 2014 оны 6 сарын 3 ны өдрийн 2/748 тоотын 3 дугаарт заасан албан тоотын дагуу суурь сургалтаас үргэлжүүлэн суралцуулахаар шийдвэрлэсний дагуу МАУОУС-ийн оюутан 1, 2-р дамжаанд анагаахын суурь боловсролын чиглэлээр эрүүл физиологи, биохими, удамзүй, дархлаа судлал, анатоми, эмгэг судлал зэрэг анагаах ухааны суурь боловсролын хичээлүүдийг судлаад, гурав, дөрөв дүгээр дамжаанаас мэргэжлийн суурь хичээл болох ХАУ-ы дотор өвчний онош зүй, эмнэл зүй, эмийн түүхий эд, эмийн жор судлал хичээлүүдийг судлан, эмнэлзүйн дуураймал орчинд гардан үйлдэх ур чадварыг эзэмшиж, 5, 6 дамжаанд багшийн хяналтан дор сэдвийн дагуу үйлчлүүлэгчийг эмчлэх эмнэл зүйн дадлагажих сургалтуудыг АШУҮИС-ийн МАУТЭ-ийн орчинд хийж гүйцэтгэдэг.
- Зүү төөнө заслын сургалтын хөтөлбөрийн агуулгад жил тутам дүн шинжилгээ хийдэг бөгөөд 2017 онд сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан нийт 82 хичээлийн хөтөлбөрийг БШУ сайдын 2014 оны 04 сарын 28-ны А/174 тоот тушаалд дурдагдсан "Бакалаврын мэргэжлийн чиглэлд тавигдах нийтлэг шаардлага"-ын дагуу боловсруулж батлуулсан ба 2021 онд мэргэжлийн суурь-13, мэргэшүүлэх-11, дадлагажих эмнэлзүйн сургалт-2 (6), нийт 30 хичээлийн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, сургалтанд хэрэгжүүлж байна.
- МАУОУС-ийн багш нар 2021 онд 86 хичээлийн 1416 цагийн 708 видео хичээл, цахим лекцийг бичүүлж, 88 хичээлийн дадлагыг цахимаар удирдан явуулсан байна. Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан сонгон суралцах мэргэжлийн суурь хичээлийг цахимжуулан лекцийн хичээлийг цахим байдлаар сургалтанд хэрэглэж байна. Зүү эмчилгээний сүвийн байршил зүйн 10 гаруй бичлэг, уламжлалт бариа засалд 10 гаруй видео бичлэг, 300 гаруй эрүүл болон өвчин эмгэгийн үеийн хэл оношилгооны дижитал зураг, 30 гаруй шээс оношилгооны дижитал зураг, хийн дасгалын 2 бичлэг хичээлүүдийг сургалтандаа ашигладаг.
- АШУҮИС-ийн Сургалтын технологи, чанарын хяналтын журам заасны дагуу Танилцах дадлага, Орчин үеийн АУ-ны эмнэлзүйн дадлага, ХАУ-ны эмнэлзүйн дадлага хэлбэрүүдээр дадлагажуулахаар зүү төөнө заслын эмчийн мэргэжилтний Сургалтын ерөнхий төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлдэг.
- 2017 оноос эхлэн АШУҮИС-ийн Уламжлалт анагаах ухаан, зүү төөнө заслын бакалаврын диплом АНУ-ын Вашингтон мужид байрлах Зүү эмчилгээ болон Дорнын анагаах ухааны үндэсний гэрчилгээ олгох төвд /National Certification Commission for Acupuncture and Oriental Medicine/ албан ёсны магадлан итгэмжлэгдсэн кодтойгоор хүлээн зөвшөөрөгдсөн.

### **Анхаарах асуудал:**

- АШУҮИС-ийн МАУОУС-н Зүү төөнө заслын бакалаврын боловсролын сургалтын хөтөлбөртөө өөрийн үнэлгээ тасралтгүй хийж сайжруулах
- Сургалтын хөтөлбөрт онол дадлагын хичээлийн уялдаа холбоог сайжруулан мэдлэгийг цогц чадамжийн хүрээнд олгоход сургалтын хөтөлбөрийг ажил олгогч төрийн болон төрийн бус байгууллагуудтай харилцан мэдээлэл солилцох
- Бусад мэргэшлээр хөрвөх боломж дутмаг байгааг анхаарах

- Төгсөлтийн дараа мэргэших төрөлжсөн болон нарийн мэргэшлийн сургалт хязгаарлагдмал.

### **Зөвлөмж:**

- Дадлагын ажлын тайланд шинжилгээ хийж, сайжруулдаг байх
- Ажлын байрны эрэлт хэрэгцээний судалгааг давтан хийж, нийслэл, аймгийн захиалгаар томилон ажлуулах зэрэг хамтын үйл ажиллагааг идэвхжүүлэх
- Төгсөлтийн дараах нарийссан чиглэлээр суралцах боломжийг хангах

### **Дүгнэлт:**

Тус дэд шалгуурын хувьд анхаарах асуудлыг зөвлөмжийн дагуу сайжруулах боломжтой

### **Үнэлгээ: Бүрэн хангасан**

## **2.2 Сургалтын арга зүй**

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

### **Илрэл нотолгоо:**

- Зүү төөнө заслын хөтөлбөрт оюутныг бие даан хөгжихөд чиглэгдсэн сургалтын “SPICEST” загвар сургалтын дэвшилтэт арга технологи болох асуудалд суурилсан сургалт, дадлага явуулах эмнэлзүйн эмнэлгийн орчин, интерактив лекц, тохиолдолд суурилсан сургалтыг амжилттай хэрэгжүүлж байна.
- Суралцагч төвтэй, бие даан суралцах бололцоог хангах, хичээлийг PBL,LBL, эмнэлзүйн тохиолдолд суурилсан дадлага хичээл зэрэг жижиг бүлгийн сургалтаар явуулдаг болсон
- Хичээлийн нэг багц цаг нь сургалтын 48 цагтай тэнцүү. 16 цаг лекц, 24 цаг дадлага, 8 цаг бататгах бие даалт

### **Онцлог зүйл:**

- Багш нарын сургалтын арга зүйг дээшлүүлэх чиглэлээр 20 гаруй сургалтад хамруулсан.
- PBL сургалтанд 6 багш, LBL-1, ментор сургалтанд -2 багш, АУБоловсрол судлал-10, эмнэлзүйн харилцааны ур чадвар заах арга зүйн сургалтанд 3 багш тус тус хамрагдсан байна.
- Мэргэжлийн онцлогоос хамааран Иог бясалгал, Онош зүй, Хийн дасгал сонгон суралцах хичээлүүдийг сонгон зайн сургалтаар суралцах боломжтой болсон.
- 2020 оноос цар тахлаас үүдэн хичээлүүдийг зайн сургалтаар явуулж эхэлсэн ба цахим, танхим хосолсон хэлбэрээр явуулж байна.
- АШУҮИС-ийн сургалтын бодлогын үндсэн стратеги нь суралцагчийн бие даан суралцахыг сургалтын хөтөлбөрийн хүрээнд дэмжин төлөвшүүлэх, сургалт, эрдэм шинжилгээ болон эмнэлзүйн чадвар эзэмшүүлэхэд дадлага, семинарын хичээлийн агуулгын 25%-ийг танхимын бус цагаар эзэмшүүлэхээр хичээлийн хөтөлбөрт тусгадаг.

- 2016 оноос эхлэн 3, 4-р дамжааны оюутнууд зүүний сүвийн байршил зүй, зүү эмчилгээ, онош зүй зэрэг хичээлүүдийн дадлагыг сүүлийн үеийн дэвшилтэт эмнэлзүйн дуураймал орчинд гардан үйлдэл хийж дадлагажих боломжийг бүрдүүлсэн.
- Асуудалд суурилсан арга, чадамжинд суурилсан арга, харилцаанд суурилсан арга, даалгавар бие даалтанд суурилсан арга, багаар ажиллах арга, үзүүлэн таниулах аргуудыг ашиглан хичээл сургалтын үйл ажиллагааг явуулж байна.
- Оюутнууд онолын сэвдийг гүнзгийрүүлэн судлах, багшийг дагалдан гардан үйлдэлд суралцах, ЭШХ-д оролцох, клубуудад хамрагдах хэлбэрээр бие даан суралцдаг.

#### **Анхаарах асуудал:**

- Сургалтын арга зүйн талаарх оюутны сэтгэл ханамжийн судалгаа авах

#### **Зөвлөмж:**

- Сургалтын арга зүйн талаарх оюутны сэтгэл ханамжийн судалгаанд дүн шинжилгээ хийж хичээлийн хөтөлбөрийн сайжруулалтад ашиглах

#### **Дүгнэлт:**

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг, зөвлөмжийг анхаарч ажиллах боломжтой.

#### **Үнэлгээ: Бүрэн хангасан**

### **2.3 Суралцагчийн үнэлгээ**

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

АШУҮИС-ийн 2021 оны 1 сарын 28-ны өдрийн А/19 тоот тушаалаар батлагдсан “Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн төгсөлтийн өмнөх сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”

- Төгсөлтийн шалгалтанд суралцагчдын онолын мэдлэгийг “Төгсөлтийн шалгалтын журам”-ын дагуу тодорхой хугацаанд тусгай боловсруулсан сорилоор үнэлдэг. Төгсөлтийн сорилын эмхэтгэлтэй.
- Төгсөлтийн гардан (ур чадварын) шалгалтанд Төлөвлөгдсөн Зорилготой Эмнэлзүйн Шалгалт буюу “OSCE” (Objective structured clinical examination) аргыг тогтмол ашигладаг.
- Эмнэлзүйн сургалтанд (эмнэлэг, эмнэлзүйн дадлага) Миллер (Miller G.E 1990)-ын үнэлгээний аргыг нэвтрүүлсэн.
- Мэргэжлийн суурь хичээлүүдэд “360 хэм”-ийн үнэлгээний аргыг нэвтрүүлсэн.
- Ерөнхий суурь хичээлүүдийн явцын болон онолын шалгалтанд Moodle программыг өргөн хэрэглэдэг.
- 2019 оны хичээлийн жилээс Google classroom хэрэглэх болсноор Google forms-ыг түлхүү ашиглаж байна.
- Суралцагчид өөрсдийн сурлагын амжилттай чөлөөтэй танилцах, хянах боломжийг бүрдүүлсэн
- АШУҮИС-ийн ТӨСБЗГ-аас жил бүр их эмчийн мэргэжилтний төгсөлтийн онол, дадлагын шалгалтыг журмын дагуу зохион байгуулж, суралцагсдын сурлагын амжилтад анализ хийж тайлан бичдэг.
- Хичээлийн хөтөлбөрт үсгэн болон процентон үнэлгээ ашигладаг

### **Онцлог зүйл:**

- Мэдлэг үнэлэх шалгалтыг аман шалгалт, эссэ бичих, бичгийн шалгалт, олон хувилбарт сорил /А, К, В, Е хэлбэр/, Компьютерт суурилсан сорил /Е-сорил/, эмнэлзүйн тохиолдолд суурилсан сорил, бусад гэсэн хэлбэрээр авдаг.
- Ур чадвар үнэлэх шалгалтыг төлөвлөгдсөн зорилготой эмнэлзүйн шалгалт, төлөвлөгдсөн зорилготой гардан шалгалт, өртөөчилсэн шалгалт, урт болон богино хэлбэрийн эмнэлзүйн тохиолдол, гардан шалгалт, өвчтний менежмент, бусад гэсэн хэлбэрээр авдаг.
- Цогц чадамжийг үнэлэх шалгалтыг төлөвлөгдсөн зорилготой эмнэлзүйн шалгалт, төлөвлөгдсөн зорилготой гардан шалгалт, 360 хэм үнэлгээ /зөвхөн хандлага, харилцааг үнэлнэ/, Эмнэлзүйн дасгал үнэлгээ /Mini-CEX/, гардан гүйцэтгэлийн ажиглалтын үнэлгээ /DOPS/, портфель үнэлгээ бусад гэсэн хэлбэрээр авдаг.
- Оюутны эзэмшсэн эмнэлзүйн ур чадварыг эмнэлгийн дуураймал орчинд шаардлагатай муляж маникен ашиглан өртөө бүрт өөр өөр эмнэлзүйн даалгавар өгч тухайн оюутны эзэмшсэн мэдлэгийг шалгах зорилгоор 5-р дамжаанд OSCE-1, төгсөлтийн шалгалт OSCE-2 шалгалтыг тус тус зохион байгуулж авдаг.
- Хичээлийн хөтөлбөрийн дагуу Хятад хэлийг судалж HSK4 түвшний шалгалтад тэнцсэн тохиолдолд Тяньжины хятад анагаах ухааны сургуульд шилжин суралцаж, 2 сургуулийн дипломтой төгсдөг.

### **Анхаарах асуудал:**

Суралцагчийн сурлагын ахиц, амжилтад анализ хийх

### **Зөвлөмж:**

Суралцагчийн сурлагын ахиц, амжилтад хийсэн анализ, статистик мэдээллийг үнэлгээний арга зүйг сайжруулахад ашиглах

### **Дүгнэлт:**

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, цаашид тасралтгүй сайжруулахад анхаарч ажиллах боломжтой .

### **Үнэлгээ: Бүрэн хангасан**

### **ШАЛГУУР 2. ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ, ҮНЭЛГЭЭ:**

**ДҮГНЭЛТ:** Сургалтын хөтөлбөр нь сургуулийн алсын хараа стратегитэй уялдан боловсруулагдсан тасралтгүй, шинэчлэн сайжруулж ирсэн сургалтын арга зүй, үнэлгээ нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн чанартай мэргэжилтэн бэлтгэхэд чиглэсэн байна.

### **ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ: БҮРЭН ХАНГАСАН**

### **Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл**

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

### **3.1 Сургалтын орчин**



Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

### **Илрэл нотолгоо:**

- Эмнэлэг болон сургуулийн план зураг, эд хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл тэнхимийн бичиг баримтыг шүүгээнд хувилсан байдлаар товъёогжуулж хадгалсан.
- ӨМҮИС-с эмнэлэгт хөрөнгө оруулсан “Гадаадын хөрөнгө оруулалт”-ын тайланд нийт эд, хэрэгслийн бүртгэлийг дэлгэрэнгүй тусгасан нь БМИҮЗ-д илгээсэн өөрийн үнэлгээний урьдчилсан тайланд бичсэн тоо баримттай таарсан. Багаж, сургалтын хэрэгсэлийн үйл ажиллагаа хэвийн.
- Хөтөлбөрт хамрагдах хичээлүүдээс Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль хичээлийн төв байранд 40, Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн дэх АШУҮИС-ийн цогцолборт 27, сургуулийн дэргэдэх болон гэрээт эмнэлгүүд дээр хичээл орох 32 анги танхимтай.
- Улсын 6, хувийн 3 эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээ, Дорноговь, Говь-Алтай, Сүхбаатар, Дорнод, Завхан, Хэнтий зэрэг 6 аймгийн УАУ-ын төвтэй хамтран ажиллах санамж бичиг байгуулсан. АШУҮИС, МАУТЭ-ийн захирлын 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн А/14 дүгээр тушаалаар батлагдсан журам зэрэг эрх зүйн актуудын дагуу эмнэлэгүүдэд дадлагын хичээлийг зохион байгуулдаг.
- Зүү төөнө заслын тэнхимийн багш нарын тусдаа өрөөтэй, компьютерээр хангагдсан.
- Оюутны ба багш нарын цайны газар АУС-тай нэгдсэн байдлаар сургуулийн В1 давхарт байрладаг.
- Оюутны байр нь 1200 хүний багтаамжтай, 4 оюутан 1 өрөөнд амьдардаг ба 8 оюутан дундаа 1 ариун цэврийн болон гал тогооны өрөөтэй.
- Багш ажилчдын хүүхдийн цэцэрлэгтэй.
- 2017-2022 онд нийт 21 оюутан БНХАУ-ын Тяньжины ХАУ-ны сургуульд сургалтын төлбөрийн 220 сая төгрөгийн тэтгэлэгт хамрагдсан байна.
- Багш бүр өөрсдийн нөөц боломжийг ашиглан хичээлээ цахим хэлбэрт шилжүүлэн сургалтын системд байршуулсаныг УМС-с танилцав.

### **Онцлог зүйл:**

- Төсвийн болон сургуулийн хөрөнгө оруулалтаар 2019 онд 3,901,82 м/кв талбайтай 5 давхар сургууль болон эмнэлгийн зориулалт бүхий байртай болсон.
- МАУОУС-ын дэргэдэх МАУ-ы эмнэлэгт 21,669,090 төгрөг, 1,459,362 юанийн хөрөнгө оруулалт хийж, эмнэлзүйн дадлага хийх сургалтын орчинг нөхцлийг бүрдүүлсэн.
- Сувиллын 1 ээлжинд 50 хүн хүлээн авах хүчин чадалтай, 168м<sup>2</sup> талбай бүхий “Эрхэс” сувилалд оюутнууд дадлага хийн хичээллэх боломжтой болсон.
- МАУОУС-ын 5 давхарт “Зүү төөнө заслын ур чадварын төв”-тэй. Уг төвд оюутнууд хичээлийн бус цагаар чөлөөтэй хичээллэх боломжтой.
- МАУОУС-ийн 5 давхарт цахим, зайн сургалтын төв байгуулсан. АШУҮИС-ийн захирлын 2021 оны 01 сарын 28-ны өдрийн А19 тоот тушаалаар батлагдсан “АШУҮИС-д цахим сургалт эрхлэх журам”-ын дагуу сургуулийн цахим сургалтын нэгдсэн системд холбогдон тогтмол хэрэглэдэг.

- Хөтөлбөрт хамрагдах хичээлүүдээс Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль хичээлийн төв байранд 40, Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн дэх АШУҮИС-ийн цогцолборт 27, сургуулийн дэргэдэх болон гэрээт эмнэлгүүд дээр хичээл орох 32 анги танхимтай.

#### **Дүгнэлт:**

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчинд жил бүр сайжруулалт хийдэг. Дадлага хийх эмнэлгүүдтэй хамтран ажиллах сургалтын гэрээ байгуулан ажилладаг. Цахим хичээл болон танхимийн хичээлүүдийг тодорхой дүрэм, журмыг баримтлан хөтөлбөр төлөвлөгөөний дагуу зохион байгуулдаг. Багш нарын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор хүүхдийн цэцэрлэг ажилладаг, мөн залуу багш нар оюутны байранд амьдрах боломжтой, багш нарын өрөө, анги танхимуудад шаардлагатай тохижилт, хөрөнгө оруулалтыг хийж, ашиглаж байгаа нь “Дээд боловсролын сургалтын орчинд тавих шаардлага”-д нийцсэн бөгөөд уг шалгуурыг хангаж байна гэж үзлээ.

#### **Үнэлгээ: Бүрэн хангасан**

### **3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн**

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Хичээлийн ур чадварын төвүүдэд сургалтын шинэ багаж, төхөөрөмжүүдтэй, аюулгүй ажиллагааны заавруудыг орчуулан мөрдлөг болгодог. Эдгээрийг “Зүү төөнө заслын их эмч” хөтөлбөрийн оюутнууд ангийн багш нарын зөвшөөрлийн дагуу хичээлийн бус цагаар бие даан ашигладаг.
- Сургалтын цахилгаан хэрэгслүүд бүгд аюулгүй ажиллагааны заавартай.
- Зүүний сүвийн хэмжилзүйн хичээлийн 2СД хичээлийг файл хэлбэрээр оюутнуудад өгч ашиглуулдаг.
- Юнитель, Мобикомын дугаараас сургуулийн аппликэйшныг үнэгүй ашигладаг. Вэб хуудас болон уг аппликэйшнаар сургалтын нэгдсэн цахим системрүү нэвтэрч өөрийн дүнтэй танилцах, хичээлүүдээ үзэх, багш нартай болон бусад суралцагсадтай холбогдох зэргээр олон төрлийн үйлчилгээг авч болдог байна.
- Цахим сургалтын elearning, Google Classroom системүүд дээр дүн шивэх, үйл ажиллагааны тайлангуудыг тогтмол гаргаж, албаны мэргэжилтэн хүлээн авч бүртгэж ажилладаг.
- Гардан үйлдлийн сургалт, шалгалтын хэрэглэгдэхүүнийг тэнхимийн багш нарын хурлаас жагсаалт гарган салбар сургуулийн захиралд танилцуулснаар төв сургуулийн санхүү, хангамжийн албанд захиалга өгч шийдвэрлүүлдэг.

#### **Онцлог зүйл:**

- Зүү хатгах техникийн аппарат, судас болон хэл оношилгооны аппарат, зүүний сүвийн байршилзүйн моляжууд, цахилгаан зүү, төөнүүрийн аппарат, хүний биеийн ТҮЦ машин зэргийг сургалтанд ашиглаж байна. Эдгээр нь нэг ангийн оюутнууд хэрэглэхэд хүрэлцэхүйц, сургалтын шинэ дэвшилтэт материаллаг бааз болж байна.
- Сургалтыг явуулахдаа “Сургалтын технологи, чанарын хяналтын үлгэрчилсэн журам”, “Суурь сургалтын хөтөлбөрийг зохицуулах журам”, “Суралцагчийг үнэлэх

журам”, “Сонгон суралцах хичээлийг зохион байгуулах журам” зэрэг эрхзүйн хүрээнд зохион байгуулдаг.

- Цахим сургалтын elearning, Google Classroom системүүдийг сургалтанд нэвтрүүлэн тогтмол ашигладаг.
- Серверийн хурд, хүчин чадлыг 4 дахин нэмэгдүүлсэн, оюутнуудын цахим сургалтын систем дэх хэрэглээг дэмжих зорилгоор үүрэн холбооны байгууллагуудтай хамтран ажилладаг. Гар утсанд зориулсан аппликэйшн ашиглаж байна.

#### **Дүгнэлт:**

Зүүний сүвийн байршилзүй болон зүү эмчилгээний дадлага хийх аппарат хэрэгслүүд мөн сургуулийн эмнэлэг, сувилалтай. Цахим хичээл, мэдээллийн системийг хэрэглэх боломжийг хангаж үүрэн телефоны байгууллагуудтай гэрээ хийн суралцах боломжийг нэмэгдүүлж өгсөн байна гэж үзлээ.

#### **Үнэлгээ: Бүрэн хангасан**

### **3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр**

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- МАУОУС-ийн 5 дугаар давхарт 20 суудал бүхий 108 ботийн өрөө болон уншлагын танхим, бие даалтын танхимуудтай. МАУОУС-ийн байранд салбар номын сан нээж 2018 онд 650000, 2019 онд 550000, 2021 онд 896000, 2022 онд 575000 төгрөгний ном, сурах бичиг шинээр авч байжуулсан.
- Багш нар зүү төөнө заслын хичээлд хэрэглэгдэх номуудыг англи, хятад хэлнээс орчуулан хөтөлбөрт нийцүүлсэн хичээлийн агуулга бүхий ном, гарын авлага хэвлэсэн.
- Сургуулийн цахим номын фондтой.

#### **Онцлог зүйл:**

- Хэвлэмэл материалыг цахим болгоход зориулж scansnap 1500 төхөөрөмж, зөөврийн scanner худалдан авч, ховор, дахин хэвлэгдэх боломжгүй номуудыг цахим хэлбэрт оруулан ашигладаг. Багш, оюутнууд цахим кодоор номын санруу нэвтрэн уншдаг. Цахим хэрэглээг хянан, судлах боломжтой байдаг.

#### **Анхаарах асуудал:**

Гадаад ном, сурах бичгийн тоог нэмэгдүүлэх.

#### **Зөвлөмж:**

Гадаад ном сурах бичгийн жагсаалтыг жил бүр нэмэгдүүлж хөтөлбөрийн хэрэглэгдэхүүний төсөвт суулгах

#### **Дүгнэлт:**

Сургуулийн номын сан нь “Боловсролын тухай хууль”-д заасан номын санд тавигдах шаардлагад нийцсэн. Хөтөлбөрийн агуулгын хүрээнд ашиглах монгол хэл дээрх ном, сурах бичиг, гарын авалгын хангамж, хүрэлцээ сайн. Цахим номын санг ашиглахад хялбар гэж дүгнэв.

#### **Үнэлгээ: Бүрэн хангасан**

### **ШАЛГУУР 3. ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ, ҮНЭЛГЭЭ:**

**ДҮГНЭЛТ:** Тус шалгуур нь нийт 3 дэд шалгууртай бөгөөд сургалтын анги танхим, лаборатори, номын сан, оюутны дотуур байр, багш нарын өрөө, эмнэлэг, сувилал

зэрэг сурах ба ажиллах орчны байдал байнга сайжирч байгаа. Хичээлийн хэрэглэгдэхүүн, номын тоо хэмжээг жил бүр нэмэгдүүлдэг. Цахим хичээлийн зохион байгуулалт, сургуулийн системийн сайжруулалт нь сургалтын хэрэгцээг хангаж чадсан. Шалгуурын хүрээнд анхаарах асуудлыг сайжруулах бүрэн боломжтой гэж үзээд бүрэн хангасан гэж дүгнэлээ.

## **ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ: БҮРЭН ХАНГАСАН**

### **Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт**

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

#### **4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа**

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Өөрийн үнэлгээний тайлан 62-65 тал
- АШУҮИС-ийн МАУОУС-ийн Зүү төөнө засал хөтөлбөрийн тэнхимийн хурлын 2017-2022 оны тэнхимийн хурлын тэмдэглэл
- АШУҮИС-ийн УЗ-ийн 2020 онд баталсан “АШУҮИС-ийн хөгжлийн бодлого 2030”
- АШУҮИС-ийн 33-ийн хурлаар 2020 онд хэлэлцэж дэмжсэн “МАУОУС-ийн стратеги төлөвлөгөө”
- АШУҮИС-ийн МАУОУС-ийн Зүү төөнө засал хөтөлбөрийн тэнхимийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан
- АШУҮИС-ийн 2022 оны 10 сарын 27 -ны өдрийн А 225 тоот тушаалаар батлагдсан “АШУҮИС-ийн хөтөлбөрийн хорооны журам”
- Сургалтын удирдлагын болон сургалт зохион байгуулах системүүд
- Шинжээчдийн хийсэн уулзалт, ярилцлага

#### **Онцлог зүйл:**

Хөтөлбөрийн хорооны үйл ажиллагаатай. АШУҮИС-ийн захирлын 2021 оны 10-01ний өдрийн А/204 тушаалаар Хөтөлбөрийн ерөнхий хороо болон дэд хороодын гишүүдийг шинэчлэн баталсан. Тайлангийн хугацаанд

- ✓ тэнхимийн хурлаар 6 удаа,
- ✓ хөтөлбөрийн дэд хороогоор 5 удаа,
- ✓ хөтөлбөрийн ерөнхий хороогоор 1 удаа уг хөтөлбөрийн асуудлыг хэлэлцэн сайжруулалт хийсэн байна.

Багш нарын оролцоог хангах зорилгоор хөтөлбөрийн дэд хорооны нарийн бичгийн даргаар жилийн хугацаатай ээлжлэн ажиллуулдаг.

- АШУҮИС-ийн хэмжээнд нэгдсэн байдлаар засаглалын бодлого хэрэгжүүлэх боломжтой. 2016 оны 06 сарын 16-ны өдрийн тушаалаар АШУҮИС-ийн Монгол Анагаах Ухааны Олон Улсын сургууль болон өргөжиж үйл ажиллагаа явуулж байна.

- Жил бүр багш нар ажлын төлөвлөгөө боловсруулан гүйцэтгэл, биелэлтийг тайлагнаж хэвшсэн.
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж болох тэнхим, бүрэлдэхүүн сургууль нь АШУҮИС-ийн стратеги төлөвлөгөөний нэг хэсэг болж үйл ажиллагаандаа дэмжлэг авах боломжтой.
- Сургалтын удирдлагын болон сургалтын нэгдсэн программ хангамжтай.

#### **Анхаарах асуудал:**

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь төлөвлөлт тайлагналын нэгдсэн загвар боловсруулж тайлангийн үр дүнг нэгтгэн цаашид авах арга хэмжээг тодорхойлдог, түүнийг оролцогч талуудад таниулдаг байх

#### **Зөвлөмж:**

- Сургууль нэгжийн төлөвлөгөөний биелэлтэнд дүгнэлт хийн мэдээлэл түгээдэг байхаас гадна оролцогчдын оролцоог нэмэгдүүлэхэд чиглэн төлөвлөлт, тайлагналын нэгдсэн загварыг АШУҮИС-ийн хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөөнд нийцүүлэх
- Сургалтын удирдлагын XCloud.mn программ хангамжийн ашиглалтыг мэдээллийн урсгал, удирдлагын шийдвэр гаргалтын чиглэлээр ашиглах боломжтой байгааг харгалзан статистик мэдээллын сан бүрдүүлэх, багшийн ажлын тайлан төлөвлөгөөний биелэлт нэгтгэх, мэдээллийн урсгалыг сайжруулахад ашиглах

#### **Дүгнэлт:**

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь хөтөлбөрийн ерөнхий болон дэд хороодын зохион байгуулалтанд үйл ажиллагаа явуулдаг, аливаа асуудал дэвшүүлэх шийдвэрлэх, төлөвлөх тайлагнах үйл ажиллагааг журмын дагуу хэрэгжүүлдэг. Хурлын шийдвэр, тэмдэглэл, төлөвлөгөө тайлагналыг бичиг баримт боловсруулалтын нэгдсэн стандартаар боловсруулах, архивлах баримтжуулах үйл ажиллагаандаа анхаарч ажиллах боломжтой.

### **Үнэлгээ: Бүрэн хангасан**

#### **4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ**

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Өөрийн үнэлгээний тайлан 70-72 тал
- Хамтын ажиллагааны гэрээ хэлцэл
- Сургуулийн вэб сайт, мэдээлэл

#### **Онцлог зүйл:**

- Эмнэлэг сувилалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа олон байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээ байгуулсан, тэдгээрт багш оюутныг урт, богино хугацаагаар сургах, дадлагажуулах боломжтой. 2017 оноос хойш нийт 25 гэрээ шинээр хийгдснээс 2022 оны эцсийн байдлаар 21 гэрээ идэвхитэй хэрэгжиж байна.
- Нийгмийн бүх давхаргад үйлчилгээ үзүүлэх, зөвлөн туслах боломжтой төдийгүй өнөөдрийг хүртэл хөдөлмөрийн зах зээлд нийлүүлсэн боловсон хүчний нэр хүнд сайн, үйлчлүүлэгчийн тоо нэмэгдэх хандлагатай.
- Хөтөлбөрөөр суралцагчид тайлангийн хугацаанд хэд хэдэн төрлийн тэтгэлэгт хамрагдсан.

- ✓ хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэгч БНХАУ-ын ХАУИС-аас 19 оюутан тус бүр жилийн 15,0-20,0 юанын сургалтын тэтгэлэгт хамрагдсан. Гэрээний дагуу цаашид ч оюутнуудыг ийм төрлийн тэтгэлэгт хамруулах боломжтой.
  - ✓ Хувь хүний сангийн тэтгэлэг 5 оюутанд тус бүр 1500,0 төг
  - ✓ Тяньжин хотын засаг даргын тамгын газрын тэтгэлэг 3 оюутан (цахимаар)
- Хөтөлбөрийн багш оюутнууд жил тутам
- ✓ Өрхийн эмнэлэгүүдэд үзлэг оношлогоо хийх
  - ✓ Түшиц эмнэлэгтэй хамтран өдөрлөг зохион байгуулж үзлэг оношлогоо хийх, зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлуудыг хийдэг.
- Доктор багш нар өөрийн судалгааны ажилд туслахаар ахисан түвшний суралцагчид, резидент эмч нарыг оролцуулдаг.
- Бүрэлдэхүүн сургуулийн төгсөгчдийн холбооны үйл ажиллагааг 2020 онд ТББ хэлбэрээр эхлүүлж, шинэ хөтөлбөрүүдээ сурталчилах зорилго тавьсан.

#### **Анхаарах:**

- Хөтөлбөрийн оролцогч талуудтай хамтран ажиллах гэрээний үр дүнг дүгнэдэг байх
- Төгсөгчдийн холбоотой хамтран ажиллах үйл ажиллагаа сул
- Суралцагчдын хамрагдах боломжит тэтгэлэг хөтөлбөрийн мэдээллийг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаа сул

#### **Зөвлөмж:**

- Салбарын байгууллагуудтай хамтран ажиллах талуудын гэрээгээр хүлээсэн үүргийг дүгнэсэн акт баримтыг үйлдэх
- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааг хөтөлбөрөөр төгсөгчдийн эргэх холбоог идэвхижүүлж, төгсөгчдийн тасралтгүй боловсролыг дэмжих чиглэлд хөгжүүлэх
- Суралцагчдын хамрагдах боломжит тэтгэлэг хөтөлбөрийн төрлийг нэмэгдүүлэх хөтөлбөрийн санхүүгийн бие даасан байдлыг хангах

**Дүгнэлт:** Оюутныг дагалдуулан сургах, багш нарыг эмнэлгийн байгууллагад хамтран ажиллах хамтын ажиллагааны гэрээний биелэлтийг дүгнэх, цаашид авч сайжруулах чиглэлийг тодруулахад анхаарч ажиллах боломжтой.

#### **Үнэлгээ: Бүрэн хангасан**

### **4.3 Санхүүжилт**

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

#### **Илрэл нотолгоо:**

- МАУОУС-ийн төсөв гүйцэтгэл, Зүү төөнө заслын хөтөлбөрийн 2017-2022 оны бакалаврын орлого, тэнхимийн төсвийн хэлэлцүүлгийн тэмдэглэл, төсвийн гүйцэтгэл
- Шинжээчдийн хийсэн уулзалт ярилцлага

#### **Онцлог зүйл:**

- АШУУИС нь төвлөрсөн санхүүгийн үйл ажиллагаатай бөгөөд сүүлийн жилүүдэд төсвийн төлөвлөлт, орлого зардал хуваарилалтийн бодлогоор төвлөрлийг сааруулах эхний алхамууд хийгдэж байна. Үүнд:
  - ✓ Нэгдсэн төсөв хийхэд хөтөлбөр хэрэгжүүлэгчидээс санал авдаг соёл тогтсон.

- ✓ Оюутны дадлага хийх материаллаг бааз нь салбарын эмнэлэгийн байгууллагуудад түшиглэдэг тул төсвийн бүрэлдэхүүнд багш ажилчдын цалингийн зардлын эзлэх хувь өндөр байдаг
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн үйл ажиллагааны орлого зардлын хувь хэмжээ тайлангийн хугацаанд дараах байдалтай байна. Үүнд:

- ✓ Оюутны тоо жил тутам дунджаар 30 орчим хувиар өссөнтэй холбоотой сургалтын төлбөрийн орлого жил тутам 34 хувиар өссөн байна. Суурь онтой харьцуулбал 4 дахин өссөн.

- ✓ Хөтөлбөрийг санхүүжүүлэх зардал жил тутам өсөж байгаа нь багшлах бүрэлдэхүүний болон оюутны тооны өсөлттэй холбон тайлбарлагдаж байна. Тухайлбал цалин хөлсний зардал суурь оноос 3 дахин, хичээл практикийн зардал 2 дахин, сургалтын болон бусад тоног төхөөрөмж худалдан авах зардал 26,5 сая төгрөгөөр нэмэгдсэн бол багш хөгжүүлэх зардал, эрдэм шинжилгээ судалгааны зардлын өсөлт мэдэгдэхүйц биш байна.

- БНХАУ-ын Тунляогийн Их сургуулиас Нэгдсэн эмнэлэгийн уламжлалт анагаах ухааны клиникийн байрны нэг жилийн түрээсэнд 48,6 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

#### **Анхаарах асуудал:**

- Сургалтын төлбөрөөс бусад хэлбэрээр орох орлогын нэр төрөл хэмжээг нэмэгдүүлэх
- Сургалтын төлбөрийг зарцуулж буй чиглэлүүдээр зарцуулалтын үр ашгийг тооцоолох, нэг оюутны сургалтын төлбөрийн задаргааг хийн шаардлагатай тохиолдолд нэмэлт санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэж ажиллахад анхаарах

#### **Шаардлага:**

- Хөтөлбөрийг санхүүгийн хувьд бие даасан байдлыг хангаж ажиллахад анхаарч элсэлтийг хяналтын тоонд хүргэж бүрэн авах, элсэж орсон суралцагчдын тогтоон барихад гадаад дотоодын олон нэр төрлийн сургалтын болон бусад чиглэлийн тэтгэлэг авах боломжуудыг нээх, мэдээллээр бүрэн хангахад анхаарч ажиллах шаардлагатай.

#### **Дүгнэлт:**

Хөтөлбөрийн орлогын эх үүсвэр нь зөвхөн сургалтын төлбөр байгаа нь хөтөлбөрийг санхүүгийн хувьд эрсдэлд оруулах магадлалтайг анхаарч үндсэн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх (сургалт эрдэм шинжилгээ багш хөгжүүлэх чиглэлээр) боломжийг хязгаарлаж байгааг анхаарч ажиллах

#### **Үнэлгээ: Хэсэгчлэн хангасан**

#### **4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт**

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Өөрийн үнэлгээний тайлан 75-76 тал
- АШУҮС-ийн маркетингийн газрын 2022 оны төлөвлөгөө, гүйцэтгэл
- Сургууль тэнхимийн цахим хуудас, танилцуулга
- Шинжээчдийн хийсэн уулзалт, ярилцлага

#### **Онцлог зүйл:**

- Элсэлтийн нэгдсэн болон тусгай бодлого хэрэгжүүлэх, уг үйл ажиллагаанд хөтөлбөр хэрэгжүүлэх тэнхим нэгжээс гадна бүрэлдэхүүн сургууль, нэгдсэн сургууль, салбарын яамны бодлого хэрэгжүүлэх боломжтой.
- Сургууль хөтөлбөрийн цахим хуудас, танилцуулгууд, эрдэм шинжилгээний сэтгүүлүүд, оюутны клубуудын үйл ажиллагаа, фэйсбүүк хаягаараа дамжуулан мэдээлэл хүргэдэг. АШУҮИС-ийн нэгдсэн зохион байгуулалтаар хөтөлбөр сурталчилах үйл ажиллагааг хийдэг.
- АШУҮИС-ийн маркетингийн газар төлөвлөгөө гарган гүйцэтгэл тайлагнаж ажилладаг. Түүний хүрээнд хөтөлбөр олон нийтэд мэргэжлийн мэдээлэл түгээх, улс орны өнцөг булан бүрт ажиллаж байгаа сургалтанд хамруулан тасралтгүй боловсролыг дэмжих, сургалтын хөтөлбөртэй холбоотой контентууд хийн нийтийн хүртээл болгож элсэгчид, оролцогч талуудад мэдээлэл өгөх зэргээр ажиллах боломжтой.
- АШУҮИС нэгдсэн байдлаар хөтөлбөр сурталчилах өдөрлөг зохион байгуулдаг.

#### **Анхаарах асуудал:**

-Оролцогч талуудын идэвхижүүлэлтийн үйл ажиллагааны төлөвлөлт сул

#### **Зөвлөмж:**

- Нэгжийн маркетингийн нэгдсэн төлөвлөгөө боловсруулж хөтөлбөрийн үндсэн зорилгыг таниулахад чиглэсэн нөлөөллийн ажлуудыг хийж гүйцэтгэх
- Хөтөлбөрийн багшлах бүрэлдэхүүний чадавхийг ашиглан дотооддоо нөлөөллийн бодлого хэрэгжүүлж хөтөлбөрийн байр суурийг бэхжүүлэх, оюутны хөгжлийн хөтөлбөрөөр дамжуулан элсэлтийн тоо, сургалтын анги дүүргэлтийг нэмэгдүүлэх

#### **Дүгнэлт:**

Элсэгчдэд зориулсан танилцуулга зэргээр дамжуулан хөтөлбөрийн оролцогч талуудыг идэвхижүүлэх, хөтөлбөрийн мөн чанар, зорилго зорилтыг таниулах ажилд хөтөлбөр хэрэгжүүлэгчдийн оролцоог нэмэгдүүлэх боломжтой.

#### **Үнэлгээ: Бүрэн хангасан**

### **4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал**

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

**Илрэл нотолгоо:** /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

- Өөрийн үнэлгээний тайлан 76-77 тал
- Сургуулийн вэб хуудас, танилцуулга материал, эрдэм шинжилгээний бүтээл, самбар
- Сургалтын удирдлагын программ UNIMIS
- Шинжээчдийн хийсэн уулзалт ярилцлага

#### **Онцлог зүйл:**

- АШУҮИС-ийн вэб сайтанд нэгдсэн мэдээлэл түгээх, хөтөлбөр хэрэгжүүлэгч бүрэлдэхүүн сургууль нэгжийн зүгээс үйл ажиллагааны цар хүрээг тогтоон мэдээлэл түгээх боломжтой.
- Сургалтын удирдлагын программ нь оюутан, багш болон сургалт удирдан зохион байгуулж буй нэгжийг сургалтын процессийн мэдээллээр хангаж ажилладаг.
- Сургуулийн орчинд хэрэглэгддэг цахим хуудсууд:
  - ✓ Mnms.edu.mn - Сургуулийн вэб хаяг бөгөөд бүрэлдэхүүн сургуулиудын талаарх мэдээллийн авах боломжтой



✓ Fb: Анагаахийн шинжлэх ухааны үндэсний их сургууль – 76 мянган дагагчтай

### **Анхаарах асуудал:**

Судалгааны болон соён гэгээрүүлэх чиглэлийн сонин сэтгүүл, борошур, вэб сайт тогтмолжуулан ажиллуулж нийгмийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, харилцан туслах

### **Зөвлөмж:**

Сургууль, нэгжийн үйл ажиллагааг олон нийтэд таниулах, оролцогч талыг сургууль дах үйл ажиллагаа, багш оюутны хөгжлийн өнөөгийн байдалтай танилцуулах ажлыг тасралтгүй хийх

### **Дүгнэлт:**

Оролцогч талуудад ил тод нээлттэй мэдээлэл түгээх боломжит сувгуудыг нэмэгдүүлэх замаар багш ажилтнууд, суралцагчид, төгсөгчидийг хөгжүүлэх, ажил олгогчидыг мэдлэгжүүлэх ажлыг хийх боломжтой.

## **Үнэлгээ: Бүрэн хангасан**

### **ШАЛГУУР 4. ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ, ҮНЭЛГЭЭ:**

**ДҮГНЭЛТ:** Хөтөлбөр эрэлт хэрэгцээ ихтэй, цаашид хөгжих боломжтой байдал нь давуу талыг бий болгож байна. Хөтөлбөрийг хөгжүүлэх, санхүүгийн хувьд бэхжүүлэх, багш оюутны эрдэм судлалын ажлыг санхүүжилтээр дэмжих үйл ажиллагааг нэгдсэн бодлоготой хэрэгжүүлэх, хөтөлбөрөөр суралцагчийн тоог нэмэгдүүлэх, сургалтын төлбөрөөс бусад эх үүсвэрийн орлогыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах боломжтой.

### **ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ: БҮРЭН ХАНГАСАН**

### **Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа**

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

#### **5.1. Суралцагч сонгох, элсүүлэх**

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Хэрэгжиж байгаа дүрэм журмуудыг “Сургалтын бодлого зохицуулалттай холбоотой дүрэм журмын эмхэтгэл”-д хэвлэн багш нарт тараасан.
- АШУҮИС-ийн вэб хуудсанд байршуулсан танилцуулга, видеотой.
- Хичээлийн жилийн эхэнд танилцуулах хичээл сургалтыг тусгай хөтөлбөр төлөвлөгөөний дагуу хуваарь гарган зохион байгуулж, үр дүнг танилцуулдаг.
- Ангийн багш томилдог.

#### **Онцлог зүйл:**

- БШУ-ны сайдын 2022 оны А/47 дугаар тушаал “Оюутан элсүүлэх журам”, АШУҮИС-ийн захиралын 2021 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн А/68 дугаар тушаал "Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн төгсөлтийн өмнөх сургалтад оюутан элсүүлэх журам" зэрэг тушаалуудыг баримтлан 2016 оноос АШУҮИС-ийн элсэлтийн бүртгэл [burtgel.mnums.edu.mn](http://burtgel.mnums.edu.mn) цахим бүртгэлийн системээр элсэлтийг явуулж, босго онооны дагуу элсэлт авдаг. 2017 онд 35, 2018 онд 36, 2019 онд 22,

2020 онд 29, 2021 онд 46 оюутан элссэн. Одоо нийт 163 оюутан уг хөтөлбөрөөр суралцаж байгаа.

- 2018-2022 оны хооронд БСШУЯ-аас 3 удаа босго онооны тухай журмыг шинэчилж гаргасан бөгөөд АШУҮИС-д элсэх босго оноо 480 байна.
- Лицей сургуулийн төгсөгчдөөс эхний 5 байрт орсон сурагчид элсэлтийн шалгалтгүй элсдэг.
- Цахим бүртгэлийн ситемд нэвтрэх үед “Зүү төөнө заслын их эмч” мэргэжлийг сурталчилсан бичлэг, танилцуулга байршуулсан.
- Шинээр элсэгчдэд сургуулийн танилцуулга хийж, гарын авлага өгч, оюутнуудыг эрүүл мэндийн үзлэгийг зохион байгуулдаг.

#### **Анхаарах асуудал:**

- Ажил олгогчдод чиглэсэн мэргэжил сурталчилах үйл ажиллагаа дутмаг.

#### **Зөвлөмж:**

ЗТЗ-ын эмч мэргэжлийг сурталчилах мэдээлэл яриа хийх, материал тараах замаар ажил олгогч нарт уг мэргэжлийг сурталчилах

#### **Дүгнэлт:**

Боловсролын тухай хууль болон БШУ-ы сайдын тушаалуудыг үндэслэл болгон элсэлтийн журам боловсруулан дагаж мөрддөг. Шинээр элсэгчдэд зориулсан удиртгал хичээл, эрүүл мэндийн үзлэг зэрэг төлөвлөгөөт ажлуудыг зохион байгуулж хэвшсэн байна.

#### **Үнэлгээ: Бүрэн хангасан**

### **5.2. Зөвлөн туслах үйлчилгээ**

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- “Оюутны хөгжил хөтөлбөр ажлын төлөвлөгөө, удирдамж батлах тухай” АШУҮИС-ийн захирлын 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/28 тоот тушаал.
- Оюутны сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авч дүн шинжилгээ хийж сургуулийн эрдэм шинжилгээний хуралд илтгэл бэлтгэн танилцуулдаг.
- БНХАУ-ын Тяньжины сургуулийн тэтгэлэгт суралцах хүсэлт өгсөн оюутнуудыг дэмжих зорилгоор жил бүр багш томилогдон ажилладаг.

#### **Онцлог зүйл:**

- МАУОУС-ын оюутан хариуцсан мэргэжилтэнээр 1 багш ажилладаг. Дамжаа бүрт анги даасан багшийг тушаалаар томилон ажиллуулж оюутанд тулгарсан асуудлыг шийдвэрлэх, сургалттай холбоотой мэдээлэл, зөвөлгөө өгдөг..
- “Дураараа биш дүрмээрээ” сургалтад ЗТЗ хөтөлбөрийн 45 оюутан, 2 багш, БЗХӨ, хар тамхи гэмт хэргээс сэргийлэх тухай сургалтад 54 оюутан 1 багш оролцсон
- “Оюутны хөгжил хөтөлбөр ажлын төлөвлөгөө, удирдамж батлах тухай” АШУҮИС-ийн захирлын 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/28 тоот тушаалын дагуу төлөвлөгөө гарган үйл ажиллагаанууд зохион байгуулснаас “Дархан хил” сэдэвт аянд ЗТЗ-ын ангийн 2 оюутан хамрагдан улсын хил дагуу тойрон аялалд оролцсон.

Мөн “Жижүүр анги” сэдэвт аянд хуваарийн дагууЗТЗ-ын ангийн бүх оюутнууд оролцсон.

- Ирээдүйн ажил, мэргэжилд зөвөлгөө өгөх, сэтгэлзүй, хууль эрхзүйн чиглэлийн сургалтанд ЗТЗ-ын ангийн 52 оюутан, 3 багш оролцож сургалтын үр дүнг МАУОУС-ийн захиралд тайлангаар танилцуулсан.

#### **Анхаарах асуудал:**

Суралцагсдад зориулсан үйл ажиллагаа, ангийн багшийн оюутнуудтайгаа ажилласан ажлын төлөвлөгөө, тайланг авч нэгтгэдэг байх.

#### **Зөвлөмж:**

Шинээр элсэгчдээс гадна анги дэвшин суралцагчдад мэргэжлийн тухай яриа, мэдээлэл, танилцуулга хийж байх.

#### **Дүгнэлт:**

Сургуулиас зохион байгуулж байгаа үйл ажиллагаануудад ЗТЗ-ын ангийн оюутнууд хоцрогдолгүй оролцдог, үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг тухай бүрт гаргаж холбогдох албан тушаалтанд танилцуулдаг зэргээс оюутнуудад тодорхой хэмжээгээр хүрч үйлчилж чадаж байна гэж үзлээ.

#### **Үнэлгээ: Бүрэн хангасан**

### **5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо**

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Төв сургуулиас зохион байгуулдаг оюутнуудын урлаг, спортын арга хэмжээнүүдэд тогтмол оролцдог.
- 2022.05 сард АШУҮИС, МАУОУС-ийн “Төгсөгчидийн төгөл” мод тарих үйл ажиллагаа зохион байгуулж 250 ширхэг мод суулгахад хөтөлбөрийн оюутнууд оролцсон.
- Зүү төөнө засал судлал хөтөлбөрөөр суралцагч оюутнуудаас сургуулийн оюутны клубуудад гишүүнчлэлтэй болон шагнал, тэтгэлэг, хичээлээс гадуурх ажилд оролцсон судалгаатай. /15 оюутан сургуулийн оюутны клуб, 6 оюутан сургуулийн оюутны зөвлөлд гишүүнчлэлтэй/.
- “Улсын дархан хил” сэдэвт аялал зохион байгуулж тус хөтөлбөрөөс 2 оюутан оролцсон.
- Оюутны эрдэм шинжилгээний хуралд 4 оюутан 2 удаагийн шагналт байр эзэлсэн.
- Зүү төөнө заслын тэнхимийн дэргэдэх оюутны клубын үйл ажиллагаа Ковидын хөл хорионы улмаас зогсонги байсныг эрчимжүүлэх төлөвлөгөө гаргасан.

#### **Онцлог зүйл:**

- Тэнхимүүд тус бүртээ дэргэдэх оюутны клубтэйгээс гадна сургуулийн оюутны холбоотой.
- Жамбалдорж сангийн тэтгэлэг 5 оюутанд 1.500.000 төгрөг, 2018-2019 оны хичээлийн жилд 10 оюутныг 15000-20000 юанийн, 2020-2021 онд 4 оюутан тус бүр 22500 юанийн тэтгэлэгт хамруулан БНХАУ-ын Тяньжин хотод суралцуулсан. 2019-2020 онд 26 оюутан оюутны буцалтгүй тусламжинд хамрагдсан.
- Завхан аймгийн засаг даргын нэрэмжит шагналыг 1 оюутан 2 удаа хүртсэн.
- Тайванийн хүүхэд гэр бүлийг дэмжих сангийн нэрэмжит тэтгэлэгийг 1 оюутан 4 удаа хүртсэн.

- Баянхонгор аймгийн засаг даргийн нэрэмжит тэтгэлэгийг 1 оюутан 1 удаа хүртсэн.

#### **Анхаарах асуудал:**

Дотоод болон гадаадад зарлагддаг тэтгэлэгүүдэд нэр дэвших, гадаадын болон дотоодын эрдэм шинжилгээний хуралд оролцох ЗТЗ-ын ангийн оюутны тоо нь нийт суралцаж буй оюутны тоотой харьцуулахад цөөн.

#### **Зөвлөмж :**

-Дотоод болон гадаадад зарлагддаг тэтгэлэг, эрдэм шинжилгээний хурлын мэдээллийг ангийн багш нараар дамжуулан оюутнуудад хүргэж, хамрагдах оюутны тоог нэмэгдүүлэх.

-Тэтгэлэгт нэр дэвшсэн болон эрдэм шинжилгээний хуралд оролцсон оюутнуудыг урамшуулан, сэдэлжүүлэх аргыг боловсруулан ашиглах.

#### **Дүгнэлт:**

Оюутнуудын олон нийт, сайн дурын ажил, эрдэм шинжилгээний хурал, дотоод, гадаадын тэтгэлэгт хөтөлбөрүүдэд хамрагдсан байдлыг нэмэгдүүлэх боломжтой, АШУҮИС болон МАУОУС-ийн зүгээс зохион байгуулдаг спорт, урлагийн арга хэмжээ, олон нийтийн ажил, тэмцээн уралдаан зэрэгт ЗТЗ-ын ангийн оюутнууд тэгш хамрагдан оролцдог байна гэж үзлээ.

#### **Үнэлгээ: Бүрэн хангасан**

##### **5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн**

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Оюутны шилжилт хөдөлгөөнийг АШУҮИС-ийн захирлын 2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/19 дүгээр тушаал “Төгсөлтийн өмнөх сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”-ын дагуу явагддаг.

- АШУҮИС-ийн Оюутны хөгжил удирдлагын газар (ОХУГ) оюутны шилжилт хөдөлгөөнийг хариуцдаг бөгөөд сар бүрийн төгсгөлд оюутны шилжилт хөдөлгөөнтэй холбоотой асуудлыг нэгтгэж, боловсрол хариуцсан дэд захирлаар хянуулан, улирал тутамд буюу жилд 2 удаа АШУҮИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулдаг.

#### **Онцлог зүйл:**

- Төгсөлтийн өмнөх сургалтын үйл ажиллагааг зохицуулах журмын 6 зүйлд заасан "Оюутны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах" журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

- АШУҮИС-ийн захирлын 2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/19 дүгээр тушаал “Төгсөлтийн өмнөх сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”-д багц цаг шилжүүлэн тооцох аргачлал, суралцагчийн үнэлгээ /дүнг тооцох аргачлал, хичээл дүйцүүлэх үйл ажиллагаа зэргийг нарийвчлан тусгасан байдаг.

#### **Анхаарах асуудал:**

Оюутны шилжилт хөдөлгөөний нарийвчилсан судалгаагүй.

#### **Зөвлөмж:**

Оюутны шилжилт хөдөлгөөний нарийвчилсан судалгаа гаргаж, шилжиж буй зонхилох шалтгааныг гаргаж, зохих арга хэмжээ авч ажиллах

**Дүгнэлт:**

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнтэй холбоотой асуудлыг бүрэн шийдвэрлэх дүрэм журамтай, түүний дагуу үйл ажиллагааг зохион байгуулдаг гэж дүгнэлээ.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

**5.5. Төгсөлтийн баримт бичиг**

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

**Илрэл нотолгоо:**

2020 оны төгсөгчийн төгсөлтийн баримт бичгийн (дипломын) хуулбар

**Онцлог зүйл:**

- Төгсөлтийн диплом БСШУС-ын 2017 оны 06 дугаар сарын 5-ны өдрийн А/303 дугаар тушаалаар батлагдсан “Боловсролын баримт бичгийн загвар шинэчлэн батлах тухай” тушаалын дагуу монгол, англи, уйгаржин монгол бичгээр бичигддэг.
- Анги даасан багш нар сургалтын албатай дүнгийн тулгалт хийж, мөн АШУҮИС-ийн захирлын тушаалаар төгсөлтийн шалгалтын комисс байгуулагдан шалгалт авч дүнгүүд нь дипломонд бичигддэг.

**Анхаарах асуудал:**

Төгсөгчийн эмчлэх эрхийн гэрчилгээ “УАУ-ы их эмч” гэсэн нэрээр олгогддог.

**Зөвлөмж:**

Төгсөгчийн эмчлэх эрхийн гэрчилгээ “УАУ-ы их эмч” гэсэн нэрээр олгогдсон учир ажил олгогч, төгсөгчидийн хооронд ажил үүргийн хуваарь хийхэд үл ойлголцол гарч болзошгүй. Тиймээс удирдах дээд байгууллагад хандан эмчлэх эрхийн гэрчилгээг “Зүү төөнө заслын их эмч” нэршилтэй болгох хүсэлт өгөх.

**Дүгнэлт:**

БСШУС-ын 2017 оны 06 дугаар сарын 5-ны өдрийн А/303 дугаар тушаалаар батлагдсан “Боловсролын баримт бичгийн загвар шинэчлэн батлах тухай” тушаалын дагуу монгол, англи, уйгаржин монгол бичгээр бичигддэг бөгөөд төгсөгчдийн дипломын мэдээллийг ДБУМС-д зохих журмын дагуу оруулсан байна.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

**ШАЛГУУР 5. ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ, ҮНЭЛГЭЭ:**

**ДҮГНЭЛТ:** Тус шалгуур нь нийт 5 дэд шалгууртай бөгөөд оюутны элсэлт болон шилжилт хөдөлгөөн дүрэм журмын дагуу хийгддэг. Оюутнуудад чиглэсэн олон нийтийн болон тэтгэлэг олгох ажлууд хийгддэг, нэмэгдүүлэх боломжтой, судалгааны ажил хийх оюутны тоог нэмэгдүүлэхэд удирдагч багш, бааз эмнэлэг хангалттай, төгсөлтийн бичиг баримтыг шаардлагад заасны дагуу олгож байна. Шалгуурын хүрээнд анхаарах асуудлыг зөвлөмжийн хүрээнд сайжруулах бүрэн боломжтой гэж үзээд бүрэн хангасан гэж дүгнэлээ.

**ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ: БҮРЭН ХАНГАСАН**

**Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа**

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

## **6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого**

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

### **Илрэл нотолгоо:**

- Монгол Улсын Боловсролын тухай хууль, Дээд Боловсролын тухай хууль, БСШУЯ-ны сайдын 2020 оны А/270 тоот тушаалаар баталсан Дээд Боловсролын сургалтын байгууллагын багшид тавигдах нийтлэг шаардлага, АШУҮИС-ийн Хөдөлмөрийн дотоод журам, Багшийн алтан дүрэм, Багшийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийг тооцох журамд нийцүүлэн багшийг сонгон шалгаруулдаг. 2017-2021 онд 22 багш шинээр ажилд орсон байна. Үүнээс ЗТЗ-аар хөтөлбөр хэрэгжүүлэгч МАУОУС-д шинээр 2 багш ажилд орсон байна.
- АШУҮИС-ийн багшийн үйл ажиллагаа гүйцэтгэлийг тооцох журмын хоёрт заасны дагуу ажилд шинээр авах багшийн сонгон шалгаруулалтыг Багшийн хөгжил, цахим сургалтын газар, Захиргаа, хүний нөөцийн газартай хамтран зохион байгуулдаг.
- 2021 онд хөтөлбөр хэрэгжүүлэгч нийт 35 багштай, үндсэн багш 26, гэрээт багш 9. Бүх багш нар магистраас дээш эрдмийн зэрэгтэй бөгөөд 2 буюу 6% нь Академич, 3 буюу 9% нь АШУ-ы доктор, 16 буюу 46% нь доктор, 16 буюу 46% нь магистрын зэрэгтэй, албан тушаалын зэрэглэлийн хувьд 13 буюу 37% нь профессор, дэд профессор, 10 буюу 29% нь ахлах багш, багш, 2 буюу 6% нь дадлагажигч багшийн орон тоон дээр ажиллаж байна.  
Насны бүтцийн хувьд 25-34 насны 15, 35-44 насны 4, 45-54 насны 14, 55-аас дээш насны 2 багш ажиллаж байгаагаас харахад эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.
- Багшийн гүйцэтгэх ачаалал болон үнэлгээг албан тушаалын зэрэглэлээс хамаарч ялгавартай байдлаар тогтоосон. Дадлагажигч багш, багшийн ажлыг 3, ахлах багш, дэд профессор 4, профессор 5 жилд 1 удаа үнэлдэг. Өөрийн үнэлгээнд үндэслэн зөвлөлийн үнэлгээнээс гадна тэнхимийн эрхлэгч болон оюутны үнэлгээ өгдөг.
- Багшийн ажлын гүйцэтгэлийн болон чанарын үнэлгээнд суурилсан урамшууллын тогтолцоотой. Цалинтай бүтээлийн чөлөө, судлаач багш нарт сургалтын төлбөрийн хөнгөлөлт, тэнхимийн эрхлэгчийн ачааллыг хөнгөлөх, хортой нөхцлийн ачааллыг хөнгөлөх, орон тооны бус албан үүргийн хөнгөлөлт мөн ИФ бүхий ОУ-ын сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсний мөнгөн урамшуулал олгодог. (Урамшуулал олгох тухай. МАУОУС-ийн захирлын тушаал 2022.09.22 а/09)

### **Онцлог зүйл:**

- 2021 оноос жилд 2 удаа багшийн сонгон шалгаруулалт зарладаг бөгөөд багшийн сонгон шалгаруулалтад орох багшид тавигдах ерөнхий шаардлагад Англи хэлний ахисан түвшний мэдлэгтэй байх шаарлагыг нэмж тусгасан байна.
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч бүх багш нар магистраас дээш боловсролын зэрэгтэй. 2021 онд хөтөлбөр хэрэгжүүлэгч нийт багшийн эрдмийн зэрэг болон албан тушаалын зэрэглэлийг 2016 оныхтой харьцуулахад доктор 6%-иар, профессор, дэд профессорын 16.3%-иар өссөн дүнтэй байна.
- ЗТЗ мэргэжлийн хөтөлбөр хэрэгжүүлэгч МАУОУС-ийн нийт багш нарын 8 буюу 57% нь гадаадад, 6 буюу 42.8% нь дотоодод УАУ-ы чиглэлээр АУ-ы докторын зэрэг

хамгаалсан байна. ЗТЗ мэргэшүүлэх хичээлийн багш нар залуужиж байгаа хэдий ч эрдмийн зэрэг цолны хувьд сүүлийн 5 жилийн хугацаанд өсөлттэй байна. Гадаадад 2 багш докторын зэргээ хамгаалжээ.

- ЭШ илтгэл хэлэлцүүлэн байр эзэлсэн болон Scopus мэдээллийн санд бүртгэлтэй сэтгүүлд ЭШӨ хэвлүүлсэн тохиолдолд IF-аас шалтгаалан 300 мянган төгрөгөөс дээш мөнгөн урамшуулал, батламж олгодог. Хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нараас 2018 онд 1, 2019 онд 1, 2020 онд 1, 2021 онд 1, 2022 онд 2 багш урамшуулал авсан бөгөөд үүнээс ЗТЗ тэнхимээс 1 багш урамшуулалд хамрагдсан байна.
- Нэг багшид ноогдох оюутны тоо 2016 онд 14.5 байсан бол 2021 онд 12.8 болж буурсан байна.
- Бүх багш нар багшлах эрх авсан. Багшийн хөгжил, цахим сургалтын газраас албан тушаалын зэрэглэлээс хамаараад 1-3 жилээр сунгагддаг байна.

### **Анхаарах асуудал:**

ЗТЗ-ын тэнхимийн докторын зэрэгтэй багшийн тоог нэмэгдүүлэхэд анхаарах

### **Зөвлөмж:**

ЗТЗ-ын мэргэжлийн багшийн тоог нэмэгдүүлэх, үндсэн багш нарын эрдмийн зэрэг цолыг ахиулахад чиглэсэн тодорхой үе шат бүхий үйл ажиллагааг төлөвлөх

### **Дүгнэлт:**

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй бөгөөд зөвлөмжийн дагуу сайжруулах боломжтой гэж үзсэн тул тус дэд шалгуурыг бүрэн хангасан гэж үнэлж байна.

**Үнэлгээ: /Бүрэн хангасан/**

## **6.2. Багшийн хөгжил**

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

### **Илрэл нотолгоо:**

- Багшийн хөгжлийн төвийг Багшийн хөгжил, цахим сургалтын газар болгон өргөжүүлсэн бөгөөд Багшийн хөгжлийн хөтөлбөрийг шинээр боловсруулан хэрэгжилтийг ханган ажилладаг.
- Багшийн хөгжлийг хариуцсан нэгж нь 27 төрлийн сургалтыг сүүлийн 5 жилд зохион байгуулжээ. МАУОУС-ийн багш нараас тус сургалтад 2017 онд 20, 2018 онд 21, 2019 онд 25, 2020 онд 14, 2021 онд 30 багш хамрагдсан байна. Үүнээс ЗТЗ тэнхимийн багш нараас 2017 онд 9, 2018 онд 4, 2019 онд 4, 2020 онд 1, 2021 онд 5 багш тус сургалтуудад хамрагдсан байна. HARWARD MEDICAL SCHOOL эмнэлзүйн 6 сарын сургалтад МАУОУС-ийн 7 багш хамрагдан амжилттай төгссөнөөс ЗТЗ тэнхимийн 2 багш суралцсан байна.
- МАУОУС-ийн багш нар сүүлийн 5 жилд гадаадын 7 оронд 16 удаа урт, богино хугацаагаар мэргэжил дээшлүүлсэн бөгөөд дотоодод 4 багш илтгэл хэлэлцүүлжээ. Үүнээс ЗТЗ-ын тэнхим нь гадаадын эрдэмтэдтэй хамтран богино хугацааны 4 удаагийн багц цагийн сургалтыг зохион байгуулж, хичээл заасан байна. Мөн дотоододын 5 сургалтад 8 багш, гадаадын 4 сургалтад 6 багш хамрагдсан байна.
- Дотоодод доктор 1, гадаадад 2, мэргэжлийн зэрэг 1, төрөлжсөн нарийн мэргэжил 3, багшлах эрх, гадаад хэлний сургалт, мэдээлэл технологийн сургалт, эмнэл зүйн

ур чадварын сургалт, анагаах ухааны боловсрол судлал зэрэг сургалтад бүх багш нар хамрагдсан байна. МАУОУС-ийн багш нараас мэргэжлийн зэрэг дээшлүүлсэн 7 багш байна. Үүнээс ЗТЗ-ын тэнхимийн 2 багш мэргэжлийн зэргээ дээшлүүлсэн байна.

#### **Онцлог зүйл:**

- Багшийг хөгжүүлэхэд тэнхим болон профессорын багийн оролцоо чухал үүрэгтэй бөгөөд багшийн хөгжлийг дэмжин ажилладаг. Профессорын баг нь судалгааны тэргүүлэх чиглэлээр төсөл боловсруулах, хэрэгжүүлэх, судалгааны үр дүнг олон улсын сэтгүүлд хэвлүүлэх, практикт нэвтрүүлэх үүрэгтэй ажиллаж байна.
- Нээлттэй хичээл зохион байгуулах удирдамжтай.
- Харвард Т2 эмнэлзүйн 6 сарын сургалтад хамрагддаг.

**Анхаарах асуудал:** ЗТЗ-ын мэргэжлийн чиглэлээр гадаад болон дотоодын сургалтад хангалтгүй хамрагдаж байна.

**Зөвлөмж:** Хөтөлбөрийн багш нарын суралцах хэрэгцээний судалгааг авч, судалгаанд үндэслэн багшийн хөгжлийн хөтөлбөрт тусгах

#### **Дүгнэлт:**

Хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нар мэргэжлийн, заах арга зүй, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлдэг бөгөөд зөвлөмжийн дагуу сайжруулах боломжтой гэж үзсэн тул тус дэд шалгуурыг бүрэн хангасан гэж үнэлж байна.

#### **Үнэлгээ: /Бүрэн хангасан/**

### **6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа**

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

#### **Илрэл нотолгоо:**

- МАУОУС-ийн багш нар АШУУИС, ШУТС, БНХАУ-ӨМӨЗО-оос санхүүжилт авч 7 төслийг хэрэгжүүлж байна. Үүнээс ЗТЗ-ын тэнхим 1 төсөл хэрэгжүүлж байна. (UNESCO. Залуу судлаачдад олгох тэтгэлэг “Use of Ghee in the Common Culture Heritage and Dairy Products of Nomadic Countries along the Silk Road”. Удирдагч У.Номин-Эрдэнэ, В.Энхтуяа. 2021-2022. Нийт төсөв 10000\$.)
- МАУОУС-ийн багш нарын оюуны бүтээлийн баталгаажилт, Патент, ашигтай загварын гэрчилгээ 11, Стандарт 3-ыг батлуулсан байна. Зохиогчийн эрх 2. Үүнээс ЗТЗ-ын тэнхим 1. (Ерөнхий мэргэжлийн анагаах ухааны сургалтын нэгдмэл хөтөлбөр. Б.Лагшмаа, Т.Алтанцэцэг, Ц. Лхагвасүрэн нарын. 2020 он 50 жил)

#### **Онцлог зүйл:**

- Багш нарын эрдэм шинжилгээнд 2018-2021 онуудад 2.2-4.4 сая төгрөг, 2022 онд 12.5 сая төгрөг зарцуулсан байв.
- Багш нараа магистр, докторын зэрэг хамгаалах, дотоод гадаадын төсөлд хамруулах, судалгаа шинжилгээ хийхийг бодлогын болон санхүүгийн дэмжлэг үзүүлдэг. Үндсэн багш нар Доктор зэрэгт суралцвал төлбөрийн 30%-ийг хөнгөлдөг нь эрдэм судлалын бүтээл туурвихад дэмжлэг үзүүлж, судалгааны ажил хийх нөхцөл бололцоогоор хангаж байна.



- IF-тай сэтгүүлүүдэд өгүүлэл хэвлүүлбэл IF-ын түвшнөөс хамааран мөнгөн урамшуулал, батламж олгодог. Шилдэг багш, шилдэг тэнхмээр шалгарвал цалингийн 20%-иар шагнаж урамшуулдаг. ЭШ илтгэл хэлэлцүүлэн байр эзэлсэн Scopus мэдээллийн санд бүртгэлтэй сэтгүүлд ЭШӨ хэвлүүлсэн тохиолдолд IF-с шалтгаалан 300.000-5.000.000 хүртэл мөнгөн урамшуулал, батламж олгодог.
- Багш ажилчдад мэргэжил дээшлүүлэх сургалт, семинар, тэтгэмж урамшуулалд 2018-2022 онд 300.000-4.850.000 төгрөг зарцуулсан. Зайлшгүй шаардлагатай зардлын ангиллаар 2018 онд эрдэм шинжилгэний зардалд 14.4%, багш ажилчдад мэргэжил дээшлүүлэх сургалт, семинар, тэтгэмж урамшуулалд 5.8%-ийг, 2019 онд эрдэм шинжилгэний зардалд 14.4%, багш ажилчдад мэргэжил дээшлүүлэх сургалт, семинар, тэтгэмж урамшуулалд 5.8%-ийг, 2020 онд эрдэм шинжилгэний зардалд 30%, багш ажилчдад мэргэжил дээшлүүлэх сургалт, семинар, тэтгэмж урамшуулалд 32%-ийг, 2021 онд эрдэм шинжилгэний зардалд 10%, багш ажилчдад мэргэжил дээшлүүлэх сургалт, семинар, тэтгэмж урамшуулалд 3.9%-ийг, 2022 онд эрдэм шинжилгэний зардалд 19%, багш ажилчдад мэргэжил дээшлүүлэх сургалт, семинар, тэтгэмж урамшуулалд 7.5%-ийг тус тус зарцуулсан байна.
- 2018-2022 онд Scopus-т бүртгэлтэй сэтгүүлд хэвлүүлсэн 6 өгүүлэл байна. Хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нараас 2018 онд 1, 2019 онд 1, 2020 онд 1, 2021 онд 1, 2022 онд 2 багш урамшуулал авсан бөгөөд үүнээс ЗТЗ тэнхимээс 1 багш урамшуулалд хамрагдсан байна.
- Сүүлийн 5 жилд хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нар гадаадын санхүүжилттэй 4 төсөл, дотоодын санхүүжилттэй 3 төсөлт ажилд удирдагч болон гишүүнээр ажилласан. Патент, ашигтай загварын гэрчилгээ 11, зохиогчийн эрх 2, стандарт 3 батлуулсан.

**Анхаарах асуудал:** Багш нарын гадаад болон дотоодод хэвлүүлж, хэлэлцүүлсэн эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлийн тоо цөөн

**Зөвлөмж:**

Багш нарын бүтээлийн эрдэм шинжилгээ судалгааны ажлын үр дүнг гадаад, дотоодын ЭШ-ний хуралд илтгэл тогтмол хэлэлцүүлэх, өгүүлэл хэвлүүлэхэд дэмжлэг үзүүлэх

**Дүгнэлт:**

Хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нар эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, дотоодын болон гадаадын санхүүжилттэй төсөл хэрэгжүүлж, магистрант болон докторантуудыг судалгааны ажлаар хангаж байгаа бөгөөд зөвлөмжийн дагуу сайжруулах боломжтой гэж үзсэн тул тус дэд шалгуурыг бүрэн хангасан гэж үнэлж байна.

**Үнэлгээ: Бүрэн хангасан**

**6.4. Багшийн үнэлгээ**

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

**Илрэл нотолгоо:**

- Аттестатчилалд хамрагдах багш нарын нэрсийг Их сургуулийн захирлын тушаалаар баталгаажуулан, багшийн ажлын үнэлгээг жилд 2 удаа зохион байгуулдаг. (Багшийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг тооцох журам батлах тухай АШУҮИС-ийн захирлын 2021.05.23 А/103, Багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээний дүнгийн хуудас 2016-2017 онд 3 тэнхмийн эрхлэгч 91-100%, нэг багш 73%, 2017-2018 онд 2 багш 94-99%, 2018-2019 онд 3 багш 86-90%, 2019-2020 онд 1 багш 96%, 2020-2021 онд 1 багш 98%, 2020-2021 онд 1 багш 96% оноотой үнэлүүлсэн)
- Багш бүр өөрийн үнэлгээнээс гадна хөндлөнгийн үнэлгээгээр үнэлүүлдэг. 2014 оноос онооны системд шилжсэн. Багшийн биелүүлэх 1600 оноо нь албан тушаалын зэрэглэл харгалзахгүй.
- Шинээр ажилд орсон дадлагажигч багшийг эхний болон 3 дахь жилд, багшийн ажлыг 3, ахлах багш, дэд профессор 4, профессор 5 жилд 1 удаа үнэлдэг. Өөрийн үнэлгээний тайланг нотлох баримтын хамт Багшийн хөгжил, цахим сургалтын газрын дэргэдэх багшийн үнэлгээний зөвлөлөөр үнэлүүлэх ба уг үнэлгээ нь багшийн албан тушаалын зэрэглэл дэвших, буурах үндэслэл болдог. Тэнхмийн эрхлэгчийн үйл ажиллагааг 2 жил тутамд захирлын тушаалаар баталгаажуулсан удирдамжийн дагуу үнэлдэг. Багшийн үнэлгээг жилд 2 удаа зохион байгуулдаг бөгөөд хангалттай үнэлгээ авбал багшлах эрхийн гэрчилгээг олгох болон сунгаж, хангалтгүй үнэлгээ авбал хөдөлмөрийн гэрээ цуцалдаг.
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч бүх багш нар шалгагдсанаас бүгд амжилттай аттестатчилагдсан байна. Сүүлийн 5 жилийн хугацаанд багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэхэд ерөнхий оноо 90%-иас дээш САЙН гэж үнэлэгдсэн байна. (Багшийн ажлын үнэлгээний дүн (2018-2021 он))

#### **Онцлог зүйл:**

- Мөн Багшийн хөгжил, цахим сургалтын газрын дэргэдэх багшийн үнэлгээний зөвлөлийн үнэлгээнээс гадна тэнхимийн эрхлэгч болон оюутны үнэлгээ өгдөг нь сайшаалтай.
- Багшийн үйл ажиллагааг үнэлэхдээ нийт 100 оноогоор үнэлдэг. Өөрийн үнэлгээ 70 оноо, бүрэлдэхүүн сургуулийн захирлын үнэлгээ, Тэнхимийн эрхлэгч 20 оноо, оюутнууд 10 оноо өгдөг бөгөөд багшийн ажлыг хөндлөнгөөс үнэлэх бодитой үнэлгээ юм. Оюутны сэтгэл ханамжийн үнэлгээгээр 2018 онд 7 багш 8-10 оноо, 2020 онд 4 багш 10 оноо, 2021 онд 1 багш 9 оноо, 2022 онд 1 багш 9 оноогоор үнэлүүлсэн.

**Анхаарах асуудал:** Багшийн өөрийн үнэлгээний болон багшийн гүйцэтгэлийг үнэлэх арга зүйг сайжруулахад анхаарах

**Зөвлөмж:** Багшийн гүйцэтгэж буй сургалт, эрдэм шинжилгээ болон мэргэжлийн үйл ажиллагааг дүгнэх аргачлалыг багш нараас судалгаа, санал авч сайжруулалт хийдэг байх, судалгааг үндэслэн, багшийн сургалт, эрдэм шинжилгээ болон мэргэжлийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг зохистой харьцаанд хүргэх, дүгнэх аргачлалыг сайжруулах

#### **Дүгнэлт:**

Багш сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн чиглэлээр хичээлийн жилд 2 удаа өөрийн болон хөндлөнгийн үнэлгээгээр үнэлүүлдэг бөгөөд зөвлөмжийн дагуу сайжруулах боломжтой гэж үзсэн тул тус дэд шалгуурыг бүрэн хангасан гэж үнэлж байна.

## Үнэлгээ: Бүрэн хангасан

### **ШАЛГУУР 6. ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ, ҮНЭЛГЭЭ:**

**ДҮГНЭЛТ:** Тус шалгуур нь 4 дэд шалгууртай бөгөөд эдгээр шалгуурын хүрээнд анхаарах асуудлыг зөвлөмжийн хүрээнд сайжруулах бүрэн боломжтой гэж үзээд бүрэн хангасан гэж дүгнэлээ.

### **ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ: БҮРЭН ХАНГАСАН**

### **Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажуулалт**

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

#### **7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт**

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Чанарын үнэлгээ, баталгаажуулалтын PDCA аргаар боловсруулсан.
- Сургалтын технологи, чанарын хяналтын үлгэрчилсэн дүрмийг АШУҮИС-ийн Захирлын 2015 оны 12–р сарын 14-ний өдрийн А142 тоот тушаалаар баталж байнга сайжруулж ирсэн бөгөөд одоо АШУҮИС-ийн сургалтын технологи, чанарын хяналтын үлгэрчилсэн журам - АШУҮИС-ийн захирлын 2021 оны 01 дугаар сарын 28-ний өдрийн А19 тоот тушаал мөрдөгдөж байна
- 2021-2022 оны хугацаанд МАУОУС нь ажлын хэсгийн хурлыг 7 бүлэг шалгуур тус бүрээр удаа дараа зохион байгуулж, МАУОУС-ийн хөтөлбөрийн дэд хороогоор 2022 оны 6 сарын 2-ны өдөр, АШУҮИС-ийн хөтөлбөрийн хороогоор 2022 оны 6 сарын 17-ны өдрийн хурлаар өөрийн үнэлгээний тайлангийн явц болон шалгуур үзүүлэлтийн талаар хэлэлцүүлсэн.
- Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газартай. АШУҮИС-ийн захирлын 2021 оны 09 дүгээр сарын 08-ны А/179 тоот тушаалаар баталсан АШУҮИС-ийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийх журам”ын дагуу үндсэн үйл ажиллагаагаа явуулдаг.
- Хөтөлбөрийн хороо, хөтөлбөрийн дэд хороо нь жил бүр төлөвлөгөө, тайлан гарган хурлыг зохион байгуулж, шийдэх асуудлыг дараагийн түвшний байгууллага руу илгээдэг.
- Хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг хөтөлбөрийн хороо хагас жил тутам үнэлж тайлагнадаг. Үүнд: оюутан болон төгсөгчдөөс сэтгэл ханамжийн үнэлгээ, оюутны явцын үнэлгээ, гүйцэтгэлийн үнэлгээ (ажил олгогч, мэргэжлийн хөндлөнгийн үнэлгээ), үр нөлөөний үнэлгээг (мэргэжлийн салбар дах нөлөөллийг үнэлэх) хийсэн.
- МАУОУС-ийн оюутнуудаас сэтгэл ханамжийн судалгаа, хамтран ажиллагч, ажил олгогчдын санал асуулгыг тус тус авдаг.

#### **Онцлог зүйл:**

-Сургалтын хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын гарын авлагатай “Чанарын гарын авлага 2016”

-Дотоод сүлжээний оффис динамик UNIMIS программыг АШУҮИС-ийн захирлын 2015 оны 5 сарын 6-ны өдрийн А/55 тушаалаар нэвтрүүлэн ажилладаг. Мэдээллийн төв нь мэдээллийг хадгалах, хамгаалах, нэгтгэх, хянах үйлдлүүдийг хийдэг.

-АШУҮИС-ийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам - АШУҮИС-ийн захирлын 2021 оны 05 - дугаар сарын 13-ны өдрийн А103 тоот тушаалын хүрээнд Багшийн ажлын хавтсанд байх баримтуудад тулгуурлан хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт, үнэлгээг хийх бүрэн боломжтой.

#### **Анхаарах асуудал:**

-Төгсөгчид болон оюутнуудаас авсан судалгаанд үндэслэн сургалтын хэрэглэгдэхүүн түүний хүртээмжийг нэмэгдүүлэх, сургалтын арга зүйг сайжруулах, багшлах боловсон хүчний нөөцөд анхаарах.

-Ажил олгогчдоос авсан судалгааны үр дүнг хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг сайжруулахад ашиглах

#### **Зөвлөмж:**

-МАУОУС-ийн хэмжээнд цаашдаа чанарын баталгаажуулалтын мэргэжилтэнтэй болох, оюутан, төгсөгчид, ажил ологч нараас авсан сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авах, судалгааны үр дүнг хөтөлбөрийн сайжруулалтад ашиглах

#### **Дүгнэлт:**

Анхаарах асуудлыг зөвлөмжийн дагуу сайжруулах боломжтой гэж үзэн шалгуурыг бүрэн хангасан гэж үнэлж байна.

#### **Үнэлгээ: Бүрэн хангасан**

### **7.2. Хөтөлбөрийн үр дүн**

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

#### **Илрэл нотолгоо:**

ЗТЗ сургалтын хөтөлбөрийн явцад дүгнэлт өгч хөтөлбөр сайжруулахад оюутан, төгсөгчид, ажил олгогчидоос сэтгэл ханамжийн судалгаа авдаг.

- Оюутнуудаас сургалтын чанар, орчин, ном сурах бичгийн хүрэлцээ, үзүүлэн таниулах материалын талаар (4-6 дамжааны оюутнуудаас 18 асуулттай асуумжаар сургалтын хөтөлбөрийн талаар сэтгэл ханамжийн судалгааг авсан байна)

- Төгсөгчдөөс судалсан хичээлийн агуулга, зөөлөн ур чадвар, багш нарын заах арга зүй, материаллаг баазын хүртээмж, ажлын байрны хэрэгцээний талаар, ажил олгогч нараас төгсөгчдийн мэдлэг чадвар, харилцаа хандлага, төгссөн сургууль зэрэг асуумжаар судалгааг авсан байна.

#### **Онцлог зүйл:**

-Монголын оюутан сурагчид БНХАУ-ын их дээд сургуулиудад суралцаж Уламжлалт анагаах ухааны сургалтуудад хамрагдаж байгаа учраас Монгол улсад ЗТЗ-ын мэргэжлээр мэргэжилтэн бэлтгэх ажлыг санаачилсан байна. Анагаахын суурь хөтөлбөрөөс ЗТЗ-ын хөтөлбөрт элссэн суралцагчид АШУҮИС-ийн бусад хөтөлбөрт элссэн суралцагчидтай ижил агуулга, багтаамжтайгаар судалсан оюутнууд МАУОУС-д элсэн орох боломжийг бий болгосон.

-Сургалтын хөтөлбөрийг сургалтын бодлого зохицуулалтын газраас баталгаажуулсан загварын дагуу мэргэжлийн тэнхим ажлын хэсэг, баг зөвлөл боловсруулдаг.

-Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа, дүгнэлт, үр дүн: ЗТЗ мэргэжлээр төгсөгчдийн ажлын байрны судалгааг нийт 40 төгсөгчөөс авсан. Судалгаагаар эмчээр ажиллаж байгаа 53%, резидент, мастер 22%, 0-3 насны хүүхдээ харж буй 9%, ажилгүй 7%, бусад 9% байна.

-Төгсөгчдийн карьер өсөлтийн судалгаа, дүгнэлт, үр дүн: ЗТЗ-ын ангийг 2019 онд 20, 2021 онд 13, 2022 онд 12 оюутан нийт 45 зүү төөнө заслын их эмч төгссөн, Үүнээс 1 сургуульдаа, 4 магистрантурт, 10 хөдөө орон нутагт, хотод 31, 3 гэртээ байна

-Төгсөгчдийн ажлын байраар хангагдах хүртэл хүлээх хугацаа /7 хоногоос 1 сар байсан ярилцлагаас/

-2017-2022 онд Тяньжины их сургуулийн тэтгэлэг авсан оюутны тоо 26 үүнээс 5-6 дамжаанд суралцаж буй 7, жилийн чөлөө авсан 2, төгссөн 12, HSK 5 шалгалт өгөх 5 оюутан байна.

-Ажил олгогч нараас авсан судалгаагаар төгсөгчдийн 97% нь мэдлэг сайтай, 80% нь ур чадварт сайтай боловч 24% нь хувь хүний санаачилга, бие даан ажиллах чадвар дунд, ажлын байранд эмчийн ёс зүй, эмч эмнэлгийн ажилтны харьцаа хандлагын алдаа гаргадаг, гадаад хэлний мэдлэг дутмаг, онош тавих стандарт мөрдөх хэрэгтэй гэж үнэлсэн байна.

### **Анхаарах асуудал:**

-Төгсөгчдийн ажлын байрны судалгаа хийх

-Хөтөлбөрийн үр дүнгийн судалгааг хийх

### **Зөвлөмж:**

-Хөтөлбөрөөр суралцагчийн ахиц амжилтын судалгааг хийх

### **Дүгнэлт:**

Хөтөлбөрөөр төгсөгчдийн ажлын байр эрэлт хэрэгцээтэй байгаа бөгөөд зөвлөмжийн дагуу сайжруулах боломжтой гэж үзсэн тул тус дэд шалгуурыг бүрэн хангасан гэж үнэлж байна.

### **Үнэлгээ: Бүрэн хангасан**

### **7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх**

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

**Илрэл нотолгоо:** Сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрөл №960003, 2018.10.10. (6 жилийн хүчинтэй хугацаатай)

- ЗТЗ Мэргэжлийн индекс 091703 болж өөрчлөгдсөн. (Боловсрол, шинжлэх ухааны сайдын тушаал 2022.05.09 А/160 Мэргэжлийн чиглэл /хөтөлбөрийн нэр/, индекс шинэчлэн батлах тухай) (960003 тусгай зөвшөөрлийн хавсралт)

- БНХАУ-ын Тяньжин хотын УАУИС-тай хамтран “Зүү төөнө засал” 4+2 сургалтын шинэ хөтөлбөрийг хэрэгжүүлсэн бөгөөд олон улсын стандартад нийцсэн Монгол болон БНХАУ хоёр улсад хүлээн зөвшөөрөгдөх дипломтой төгсдөг. (Б.Төгөлдөр АШУУИС, МАУОУС D201912634, Tianjin University of Traditional Chinese Medicine 1006342019800094)

- 2019, 2021, 2022 онуудад ЗТЗ мэргэжлээр нийт 45 төгсөгч төгссөнөөс лицензийн шалгалтад төгсөгчид 100% тэнцсэн.

### **Онцлог зүйл:**

-Тус хөтөлбөрийг үндэсний болон олон улсын хэмжээнд магадлан итгэмжлүүлээгүй. Анх удаа үндэсний хэмжээнд магадлан итгэмжлүүлэхээр ажиллаж байгаа.

-УАУ, ЗТЗ-ын чиглэлээр үндсэн мэргэжил эзэмшүүлэх 2 жилийн сургалт, УАУ-ы дотор өвчин судлал, уламжлалт засал, эмнэлзүйн жор судлалын чиглэлээр 6 сарын сургалтыг явуулдаг. ЗТЗ-ын ангийг 2022 онд төгссөн 5 оюутан УАУ-ы төрөлжсөн нарийн мэргэжил дээшлүүлэх ангид элсэн орсон байна.

-Боловсролын яамнаас зохион байгуулсан HARWARD MEDICAL SCHOOL эмнэлзүйн 6 сарын сургалтад хамрагдан амжилттай төгссөн. (Сертификат)

-2021 онд ЭМЯ-наас Зүү төөнө заслын их эмчийн ажлын байрны тодорхойлолтыг баталсан

-2017 оноос эхлэн АШУҮИС-ийн Уламжлалт анагаах ухаан, зүү төөнө заслын бакалаврын диплом АНУ-ын Вашингтон мужид байрлах Зүү эмчилгээ болон Дорнын анагаах ухааны үндэсний гэрчилгээ олгох төвд /National Certification Commission for Acupuncture and Oriental Medicine/ албан ёсны магадлан итгэмжлэгдсэн кодтойгоор хүлээн зөвшөөрөгдсөн.

-2019, 2021, 2022 онуудад ЗТЗ мэргэжлээр нийт 45 төгсөгч төгссөнөөс лицензийн шалгалтад төгсөгчид 100% тэнцсэн.

-БНХАУ-ын Тяньжин хотын УАУИС-тай хамтран “Зүү төөнө засал” 4+2 сургалтын шинэ хөтөлбөрийг хэрэгжүүлсэн бөгөөд олон улсын стандартад нийцсэн Монгол болон БНХАУ хоёр улсад хүлээн зөвшөөрөгдөх дипломтой төгсдөг.

#### **Анхаарах асуудал:**

-Ажил олгогч мэргэжлийн холбоо, төгсөгчдийн холбоотой хамтран ажиллах

#### **Зөвлөмж:**

-Ажил олгогч мэргэжлийн холбоо, төгсөгчдийн холбоотой хамтран ажиллаж төгсөгчдийг ажлын байраар хангах, давтан сургах, судалгаа шинжилгээний ажил хийхэд дэмжлэг үзүүлэх

#### **Дүгнэлт:**

Хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нар дотоодын болон гадаадын мэргэжил дээшлүүлэх сургалтад тогтмол суралцдаг, суралцагчидыг Хятадын засгийн газрын тэтгэлэгт хамрагдан суралцах нөхцөл боломжийг бүрдүүлсэн бөгөөд зөвлөмжийн дагуу сайжруулах боломжтой гэж үзсэн тул тус дэд шалгуурыг бүрэн хангасан гэж үнэлж байна.

#### **Үнэлгээ: Бүрэн хангасан**

#### **ШАЛГУУР 7. ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ, ҮНЭЛГЭЭ:**

**ДҮГНЭЛТ:** Тус шалгуур нь 3 дэд шалгууртай бөгөөд эдгээр шалгуурын хүрээнд анхаарах асуудлыг зөвлөмжийн хүрээнд сайжруулах бүрэн боломжтой гэж үзээд бүрэн хангасан гэж дүгнэлээ.

#### **ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ: БҮРЭН ХАНГАСАН**

## ДҮГНЭЛТ

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	3			
2	Сургалтын үйл ажиллагаа	3			
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөөц	3			
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	4	1		4.3 Хөтөлбөрт суурилсан төсөвтэй байх
5	Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ	5			
6	Багшийн үйл ажиллагаа	4			
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	3			
	Нийт	25	1		
<b>Дүгнэлт</b>		Бүрэн хангасан			

### НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

/Нэгдсэн зөвлөмжид дээрх зөвлөмж, шаардлагыг шууд тусгахгүйгээр агуулгыг нэгтгэн сургуулийн удирдлага, хөтөлбөрийн баг бодитой хэрэгжүүлж, үр дүнд хүрэх боломжтойгоор томъёолж боловсруулсан байна./

Шалгуур	Зөвлөмж
1 Хөтөлбөрийн төлөвлөлт	-Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээний судалгааг хийж ажил олгогчийн саналыг хөтөлбөрийн сайжруулалтад тусгадаг байх
2 Сургалтын үйл ажиллагаа	-Сургалтын арга зүйн талаарх оюутны сэтгэл ханамжийн судалгаа болон Суралцагчийн сурлагын ахиц, амжилтын судалгааны үр дүнг хөтөлбөрийн сайжруулалтад ашиглах
3 Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөөц	-Ном сурах бичгийн тоог нэмэгдүүлэх
4 Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	- Төлөвлөлт тайлагналын нэгдсэн загвар боловсруулж, түүнийг оролцогч талуудад мэдээлдэг байх - Програм хангамжийг удирдлагын шийдвэр гаргалтад ашиглах - Сургалтын төлбөрөөс бусад хэлбэрээр орох орлогын нэр төрөл хэмжээг нэмэгдүүлэх - Сургалтын төлбөрийг зарцуулж буй чиглэлүүдээр

		зарцуулалтын үр ашгийг тооцоолох, нэг оюутны сургалтын төлбөрийн задаргааг хийх - Сургууль, нэгжийн үйл ажиллагааг олон нийтэд таниулах
5	Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ	-Ажил олгогчид болон шинээр элсэгчид, суралцагчдад мэргэжлийг сурталчилах үнэ цэнийг ойлгуулах, -Оюутны шилжилт хөдөлгөөний нарийвчилсан судалгаа хийж үр дүнг тайлагнах -Төгсөгчдийн эмчлэх эрхийн гэрчилгээг “Зүү төөнө заслын их эмч” нэршилтэй болгох хүсэлт өгөх
6	Багшийн үйл ажиллагаа	-Хөтөлбөрийн багш нарын суралцах хэрэгцээний судалгааг үндэслэн багшийн хөгжлийн хөтөлбөрийг сайжруулах -Багш нарын эрдэм шинжилгээний ажлын үр дүнг олон нийтийн хүртээл болгоход дэмжлэг үзүүлэх
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	МАУОУС-ийн хэмжээнд цаашдаа чанарын баталгаажуулалтын мэргэжилтэнтэй болох, оюутан, төгсөгчид, ажил олгогчоос сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авч хөтөлбөрийн сайжруулалтад ашиглах, ажил олгогч мэргэжлийн холбоо, төгсөгчдийн холбоотой хамтран ажиллаж төгсөгчдийг ажлын байраар хангах, давтан сургах, судалгаа шинжилгээний ажил хийхэд дэмжлэг үзүүлэх
<b>Шалгуур</b>		<b>Шаардлага</b>
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	Хөтөлбөрийг санхүүгийн хувьд бие даасан байдлыг хангаж ажиллахад анхаарч элсэлтийг хяналтын тоонд хүргэж бүрэн авах, элсэж орсон суралцагчдын тогтоон барихад гадаад дотоодын олон нэр төрлийн сургалтын болон бусад чиглэлийн тэтгэлэг авах боломжуудыг нээх, мэдээллээр бүрэн хангахад анхаарч ажиллах шаардлагатай.

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их сургуулийн Монгол Анагаах Ухааны Олон Улсын Их Сургуулийн “ЗҮҮ ТӨӨНӨ ЗАСАЛ” хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг “Анагаахын чиглэл”-н хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг У.Мягмаржав  
Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг Л.Анхцацрал  
Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг С.Оюунцэцэг  
Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг Л.Оюунцэцэг



## V. Уулзалт ярилцлагад оролцогчдын бүртгэл

### I. Багш нартай хийх уулзалт

№	Овог нэр	Албан тушаалын зэрэг	Заадаг хичээл	Ажил ласан жил	Мейл хаяг	Утас
<b>АУС</b>	Б.Амгалан	Багш	Хүүхэд	10	<a href="mailto:amgalan@mnums.edu.mn">amgalan@mnums.edu.mn</a>	
	О.Баярсайхан	Багш	Гастроэнтерологи	14	<a href="mailto:bayarsaikhan.o@mnums.edu.mn">bayarsaikhan.o@mnums.edu.mn</a>	99026930
	О.Соёмбо	Багш	Яаралтай тусламж	20	<a href="mailto:soyombo@mnums.edu.mn">soyombo@mnums.edu.mn</a>	99151824
	Д.Бямбасүрэн	Профессор	Мэдрэл судлал	23	<a href="mailto:byambasuren.d@mnums.edu.mn">byambasuren.d@mnums.edu.mn</a>	99011455
	С.Эрдэнэ	Ахлах багш	Мэс засал	33	<a href="mailto:erdene@mnums.edu.mn">erdene@mnums.edu.mn</a>	99144556
	Э.Хангай	Ахлах багш	Өрхийн АУ	9	<a href="mailto:khangai.e@mnums.edu.mn">khangai.e@mnums.edu.mn</a>	88923778
<b>БиоАС</b>	О.Зэсэмдорж	Багш	Физиологи	8	<a href="mailto:zesemdorj@mnums.edu.mn">zesemdorj@mnums.edu.mn</a>	99225977
	Э.Түмэнжин	Багш	Анатоми	10	<a href="mailto:tumenjin@mnums.edu.mn">tumenjin@mnums.edu.mn</a>	80608088
<b>НЭМ</b>	Д.Амарсайхан	НЭМС-ийн профессор	УСАУ тэнхим	28	<a href="mailto:Amarsaikhan.d@mnums.edu.mn">Amarsaikhan.d@mnums.edu.mn</a>	99286646
<b>МАУОУС</b>	Т.Алимаа	Дэд профессор	МАУСТ	21	<a href="mailto:alimaa.t@mnums.edu.mn">alimaa.t@mnums.edu.mn</a>	99171212
	З.Золзаяа	Багш	МАУСТ	5	<a href="mailto:zolzaya.z@mnums.edu.mn">zolzaya.z@mnums.edu.mn</a>	99071455
	С.Доржбат	Тэнхимийн эрхлэгч	МАУСТ	15	<a href="mailto:dorjbat.s@mnums.edu.mn">dorjbat.s@mnums.edu.mn</a>	99910999
	Н.Занди	Ахлах багш	УЗТ	16	<a href="mailto:zandi@mnums.edu.mn">zandi@mnums.edu.mn</a>	99188136
	С.Хишигжаргал	Профессор	ДӨСТ	30	<a href="mailto:khishigjargal@mnums.edu.mn">khishigjargal@mnums.edu.mn</a>	99192856
	П.Молор-Эрдэнэ	Дэд профессор	ДӨСТ	18	<a href="mailto:molorerdene@mnums.edu.mn">molorerdene@mnums.edu.mn</a>	80041465
	Б.Лагшмаа	Профессор	ЗТЗ	30	<a href="mailto:lagshmaa@mnums.edu.mn">lagshmaa@mnums.edu.mn</a>	88086897
	В.Энхтуяа	Тэнхимийн эрхлэгч	ЗТЗ	18	<a href="mailto:enkhtuya.v@mnums.edu.mn">enkhtuya.v@mnums.edu.mn</a>	96645094
	Э.Уянга	Багш	ЗТЗ	9	<a href="mailto:uyanga.e@mnums.edu.mn">uyanga.e@mnums.edu.mn</a>	98072929
	З.Энхзаяа	Багш	ЗТЗ	7	<a href="mailto:enkhtuya.z@mnums.edu.mn">enkhtuya.z@mnums.edu.mn</a>	89869002
Д.Энхмаа	Багш	ЗТЗ	7	<a href="mailto:enkhtuya.do@mnums.edu.mn">enkhtuya.do@mnums.edu.mn</a>	99798974	

### II. Оюутан, суралцагчидтай хийх уулзалт

№	Оюутны овог, нэр	Анги	Курс	Сонгосон байдал	Утас
1	н.Пунсалдулам	ЗТЗ	101	Хэсгийн ахлагч	80284408
2	н.Оюундарь	ЗТЗ	102	Хэсгийн ахлагч	94126053
3	н.Энх-Ундрал	ЗТЗ	103	Хэсгийн ахлагч	89928952
4	н.Билгүүн	ЗТЗ	202	Хэсгийн ахлагч	94953848
5	н.Даваа	ЗТЗ	203	Хэсгийн ахлагч	86317118
6	Л.Халиунаа	ЗТЗ	301	Өвөрхангай-Орон нутгийн	80510185
7	М.Болорцэцэг	ЗТЗ	301	Багануур-Орон нутгийн	80579300
8	Г.Номин-эрдэнэ	ЗТЗ	301	Төв аймаг, Урлаг спортын шилдэг сурагч	90150501
9	Б.Баянмөнх	ЗТЗ	301	Хот, Улаан загалмайн гишүүн	99682269
10	П.Надмид	ЗТЗ	301	Дотуур байранд	80148412
11	Э.Энхзаяа	ЗТЗ	302	Дотуур байранд	86960423

12	Э.Буянжаргал	ЗТЗ	302	Улаанбаатар хот	88982521
13	М.Мөнхгэрэл	ЗТЗ	302	Өвөрхангай аймаг	95882575
14	Э.Энхжин	ЗТЗ	302	Улаанбаатар хот	99405702
15	Б.Гүндэгмаа	ЗТЗ	302	Хэсгийн ахлагч, Оюутны зөвлөлийн гишүүн	99342484
16	Б.Гантуяа	ЗТЗ	401	Улаанбаатар хот	96494969
17	Г.Цэгмэд	ЗТЗ	501	Хэсгийн ахлагч, Оюутны ЭШХ-н шилдэг оролцогч	99899632
19	Э.Баярсайхан	ЗТЗ	502	Дархан уул аймаг, Дархан хот	99760429
20	Ч.Цэрэнханд	ЗТЗ	502	Улаанбаатар хот	86929248
21	Д.Элбэгсүрэн	ЗТЗ	601	БНХАУ-н ТХАУИС-н оюутан	95207007
22	Б.Азжаргал	ЗТЗ	601	БНХАУ-н ТХАУИС-н оюутан	95076077
23	Ж.Золбаяр	ЗТЗ	601	Хэсгийн ахлагч, 2021 оны Жамбалдорж сангийн тэтгэлэгт оюутан	99871720
24	У.Мөнхтуяа	ЗТЗ	601	Баянхонгор аймаг	91530088
25	Б.Одонтунгалаг	ЗТЗ	601	Говь-алтай аймаг	85262596
26	Б.Ариунзаяа	ЗТЗ	601	Багануур дүүрэг, гар бөмбөг сонирхдог	94740507

### III. Ажил олгогчидтой хийх уулзалт

№	Овог нэр	Байгууллага, албан тушаал	Утас	Мейл хаяг
	Ц.Маналжав	АШУУИС төв эмнэлгийн дотрын тасгийн эрхлэгч	94165278	<a href="mailto:Manaljav@mnums.edu.mn">Manaljav@mnums.edu.mn</a>
0.	Б.Эрдэнэчимэг	“Халиун мед центр” эмнэлэгийн дарга	99085514	<a href="mailto:contact@khaliunmed.mn">contact@khaliunmed.mn</a>
0.	Б.Мөнх-эрдэнэ	Эрдэнэт хот “Шинэ-Эрин мед” эмнэлэгийн дарга	99006268	<a href="mailto:Munkherdene08@yahoo.com">Munkherdene08@yahoo.com</a>
0.	Б.Амартүвшин	Өмнөговь, Цогтцэций сум дундын эмнэлгийн Ерөнхий эмч	88145853	<a href="mailto:Amartuvshinbad88@gmail.com">Amartuvshinbad88@gmail.com</a>
0.	С.Алтанцэцэг	БГД-ийн 18-р хороо ӨЭМТ ӨЭМТ-ийн дарга	99290706	<a href="mailto:enhturhiinemneleg@gmail.com">enhturhiinemneleg@gmail.com</a>
0.	Б.Батсуурь	Уламжлалт анагаах ухааны аюур эмнэлэг Эмнэлгийн дарга	80081177	<a href="mailto:ayur.emneleg@gmail.com">ayur.emneleg@gmail.com</a>
0.	Н.Даваажав	Хөвсгөл аймаг Цагаан нуур сум ЭМТ, эмч	95782583	<a href="mailto:nymaadavaajav12@gmail.com">nymaadavaajav12@gmail.com</a>
0.	М.Сарантуяа	Оношмед сувилахуйн төвийн дарга	88029191	<a href="mailto:Mgl.saraa@yahoo.com">Mgl.saraa@yahoo.com</a>

0.	Д.Уянга	Натурмэд эмнэлэгийн тасгийн эрхлэгч	88084245	
0.	Б.Ган-өрнөх	“Монг-эм” эмнэлгийн дарга	99063763	<a href="mailto:B.ganurnukh@yahoo.com">B.ganurnukh@yahoo.com</a>

#### IV. Төгсөгсөгчидтэй хийх уулзалт

№	Овог нэр	Төгссөн он	Байгууллага, албан тушаал	Утас	Мейл хаяг
	Б.Төгөлдөр	2019	АШУУИС ТӨСБЗГ, Аргазүйч	89068102	<a href="mailto:tuguldur.b@mnums.edu.mn">tuguldur.b@mnums.edu.mn</a>
0.	Мөнххулан	2019	АШУУИС төв эмнэлэг, Уламжлалтын эмч	91012313	<a href="mailto:munkhkhulan@mnums.edu.mn">munkhkhulan@mnums.edu.mn</a>
0.	Б.Болорчимэг	2019	“Чуан Мэн” хятад компани, менежер	99705008	<a href="mailto:bolorchimeg.official@gmail.com">bolorchimeg.official@gmail.com</a>
0.	С.Отгонбаяр	2019	“Халиун мед центр” эмнэлэг, Уламжлалтын эмч	80232288	<a href="mailto:serodotgonbayar93@gmail.com">serodotgonbayar93@gmail.com</a>
0.	Сүхтогоо	2019	Эрдэнэт хот “Шинэ-Эрин мед” эмнэлэг, Зүүний эмч	95709421	<a href="mailto:suhee047@gmail.com">suhee047@gmail.com</a>
0.	Э.Батцэцэг	2020	Өмнөговь аймгийн Цогтцэций сум дундын эмнэлэг, Их эмч	88708200	<a href="mailto:Ttseegii96@gmail.com">Ttseegii96@gmail.com</a>
0.	Г.Заяа	2020	БГД-ийн 18-р хороо ӨЭМТ, Уламжлалтын эмч	94503092	<a href="mailto:g.zaya80914@gmail.com">g.zaya80914@gmail.com</a>
0.	Б.Лхамдулам	2020	Уламжлалт анагаах ухааны аюур эмнэлэг, Зүүний эмч	94606970	<a href="mailto:lhamaabaterdene635@gmail.com">lhamaabaterdene635@gmail.com</a>
0.	А.Түмэннасан	2020	Идэрмэг мэдрэлийн эмнэлэг, Зүүний эмч	99532352	<a href="mailto:tvmennasan1997@gmail.com">tvmennasan1997@gmail.com</a>
0.	Г.Содбилгүүн	2020	Соёлмэд эмнэлэг, Зүүний эмч	95010044	
0.	Д.Номин	2020	Хөвсгөл аймаг Цагаан нуур сум ЭМТ Их эмч	80624926	<a href="mailto:dawaajawnomin@gmail.com">dawaajawnomin@gmail.com</a>
0.	С.Чингүүн	2021	Оношмэд сувилахуйн төв Зүүний эмч	94228282	<a href="mailto:e.chinguunees@gmail.com">e.chinguunees@gmail.com</a>
0.	Б.Төгөлдөр-эрдэнэ	2021	Оношмэд сувилахуйн төв Зүүний эмч	80014837	
0.	Б.Гансор	2021	Натурмэд эмнэлэг Зүүний эмч, даатгалын эмч	99616655	<a href="mailto:bgansor98@gmail.com">bgansor98@gmail.com</a>

0.	Ч.Наранжаргал	2021	Монг-эм эмнэлэг уламжлалтын эмч	80884097	<a href="mailto:ch.naraa0307@gmail.com">ch.naraa0307@gmail.com</a>
0.	Э.Буянхүү	2021	АШУУИС, МДИ, МАУ Судлалын резидент	89890229	<a href="mailto:bubu.ku@icloud.com">bubu.ku@icloud.com</a>
0.	Ц.Жимсээ	2021	АШУУИС, МДИ, МАУ Судлалын резидент	95790043	<a href="mailto:jjimsee7@gmail.com">jjimsee7@gmail.com</a>
0.	Э.Цэцэгдэлгэр	2021	АШУУИС, МДИ, МАУ Судлалын резидент	86631213	<a href="mailto:tsetsegdelgerenhat3@gmail.com">tsetsegdelgerenhat3@gmail.com</a>

## V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал



АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ  
ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛЬ  
МОНГОЛ АНАГААХ УХААНЫ  
ОЛОН УЛСЫН СУРГУУЛЬ

12 дугаар хороо, Амгалан, Баянзүрх дүүрэг,  
Улаанбаатар хот, ш/х-48/111, 13270  
Утас/Факс: 7700 8666  
Цахим шуудан: ismm@mnums.edu.mn

2023.02.17 № 05  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Шинжээчийн багийн  
үнэлгээний тайлангийн тухай

АШУУИС-ийн Монгол анагаах ухааны олон улсын сургуулийн хэрэгжүүлж буй D091703 индекс бүхий Зүү төөнө заслын их эмчийн бакалаврын хөтөлбөр нь үндэсний хэмжээний хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд орж, шинжээчийн баг 2023 оны 1 сарын 17, 18 өдрүүдэд МАУОУС дээр ажилласан билээ.

Тус хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шинжээчийн багийн үнэлгээний тайлангуудтай танилцаж шинжээчийн дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх боломжтой хэмээн хүлээн авсан болно.

ЗАХИРАЛ  Д.ЦЭНД-АЮУШ  
9020080822 ± 5845459

ҮІ. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо) .....

Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт...

Зөвлөмж....

Шаардлага...

<b>Магадлан итгэмжлэх эсэх</b>	<b>Магадлан итгэмжлэл олгох хугацаа</b>

### **ҮII. Дээд боловсролын магадлан итгэмжлэх комиссын шийдвэр**

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан

(огноо).....

Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт...

Зөвлөмж....

Шаардлага...

<b>Магадлан итгэмжлэх эсэх</b>	<b>Магадлан итгэмжлэл олгох хугацаа</b>